

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт2
Төв аймгийн Аудитын газар	Нэг. Ерөнхий зүйл
	1.1 Аудитын зорилт, хамарсан хүрээ.....3
	1.2 Аудитын арга зүй.....3
Дарга, Тэргүүлэх аудитор:	1.3 Төв аймгийн ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал.....3
Л.Жаргалсайхан	Хоёр. Санхүүгийн дотоод хяналт4
Аудитын менежер:	Гурав. Шилэн данс4
О.Амаржаргал	Дөрөв. Материаллаг байдал5
	Санхүүгийн тайлангийн дансдын талаар
Ахлах аудитор:	Тав. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал
Ц.Саранчимээ	5.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар 6
Ц.Базарсад	5.2 Сангуудын мөнгөн хөрөнгийн талаар.....6
Т.Майцэцэг	5.3 Арилжааны банк дахь ТЭЗ-дын харилцах дансны талаар6
	5.4 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчлийн талаар.....6
Аудитор	Зургаа. Авлагын бүртгэл, тайлагнал
Ж.Бямбацогт	6.1 Авлагын бүтцийн талаар.....7
О.Сосор	6.2 Авлагатай холбоотой зөрчлийн талаар.....8
Э.Нарантуяа	Долоо. Бараа материалын бүртгэл, тайлагнал
	7.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар9-10
	7.2 Бараа материалын зөрчлийн талаар.....11
Шинжээч:	Найм. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал
Ц.Хишигжаргал	8.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар..... 12
А.Батлхавга	8.2 Үндсэн хөрөнгийн тайлагналын талаар.....12
	8.3 Биет бус хөрөнгийн талаар13
	8.4 Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл.....13
	8.5 Үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчлийн талаар.....13
2017 оны 4 дүгээр сар	Ес. Өр төлбөрийн бүртгэл тайлагнал
	9.1 Өр төлбөрийн бүтцийн талаар14
	9.2 Өглөгтэй холбоотой зөрчлийн талаар.....14
Уг тайланг Төв аймгийн Аудитын Газрын Цахим хуудаснаас үзнэ үү:	Арав. Орлогын бүртгэл, тайлагнал
www.tuv@audit.gov.mn	10.1 Мөнгөн гүйлгээний орлогын талаар санхүүжилт14
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273465 дугаарын утас, 70272582 дугаарын факсаар харилцана уу.	10.2 Орлого, татаас санхүүжилтийн талаар14
	10.3 Татварын болон татварын бус орлогын талаар15-16
	10.4 тусламж санхүүжилтийн талаар17
	10.5 Орлоготой холбоотой зөрчлийн талаар.....17
ХАЯГ:	Арван нэг. Зардлын бүртгэл, тайлагнал
Төв аймгийн Төрийн байгууллагын 2-р ордон	11.1 Зардлын бүтцийн талаар18
Зуунмод 6-р баг	11.2 Зардлын тайлагналын талаар.....19
	11.3 Зардалтай холбоотой зөрчлийн талаар.....20
	11.4 Шилжих үлдэгдэлийн зарцуулалтын талаар.....21-23
	11.5 Нэмэлт санхүүжилтийн талаар.....24
	11.6 Тусгай сангуудын зарцуулалтын талаар24
	11.7 Тусгай сангийн зарцуулалтын зөрчлийн талаар.....25
	11.8 ОНХСангийн талаар.....26
	Арван хоёр. Эздийн өмчийн бүртгэл тайлагнал
	12.1 Эзэмшигчдийн өмчийн бүтцийн талаар.....27
	12.2 Засгийн газрын сангийн талаар.....27
	12.3 Хөрөнгийн үнэлгээний талаар.....28
	Арван гурав. ОНӨҮГазрын бүртгэл, тайлагнал
	13.1 ОНӨҮГ-ын бүтцийн талаар.....28
	Арван дөрөв.ТЭЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитын талаар
	14.1 ТТЗ,ТШЗ-ийн СТ-д хийсэн аудитын дүнгийн талаар39-31
	14.2 ЭМБ-ийн СТ-д хийсэн аудитын дүнгийн талаар.....31
	14.3 БСалбарын СТ-д хийсэн аудитын дүнгийн талаар.....32
	14.4 СБайгууллагын СТ-д хийсэн аудитын дүнгийн талаар.....32
	14.5 АЗДБ-ын СТ-д хийсэн аудитын дүнгийн талаар32
	Арван тав. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....33
	Арван зургаа. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар.....33
	Арван долоо. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....34-35
	Арван найм. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....36
	Арван ес. Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....36
	Хорь. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....36
	Хорин нэг. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл37
	Хорин хоёр. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....37
	Хорин гурав. Аудитын гэрчилгээний тохирох дүгнэлт.....37
	Хорин дөрөв. ТЭЗ-ийн 2016 оны аудитлагдсан тайлан.....38
	Хорин тав. Холбогдох байгууллагын санал.....

Товчилсон үгийн тайлбар	
ҮАГ	Үндэсний аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТАБ	Төрийн аудитын байгууллага
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХК	Хувьцаат компани
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНТС	Орон нутгийн тусгай сан
ОН	Орон нутаг
ТЗШТБ	Тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТӨААТҮГ	Төрийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ААН	Аж ахуйн нэгж
СХАА	Санхүүгийн хяналт аудитын алба
ЖМС	Жижиг мөнгөн сан
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨҮГ	Төрийн өмчийн үйлдвэрийн газар
ОНБ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
БСУШУС	Боловсрол соёл урлаг шинжлэх ухааны сайд
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгаалалын яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОАТ	Орлогын албан татвар
ТТАМАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
АБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татвар
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
ТБӨО	Төсөвт байгууллагын өөрийн орлого
АЗЗА	Авта зам засвар арчлалт
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШҮГ	Шуудан үйлчилгээний газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
СХС	СХСан
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
БСГ	Боловсрол соёлын газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Төсвийн тухай хуулийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан УАГ-ын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд ТӨВ-2017/1/ СТА-ТЭЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

1.2 Аудитын арга зүй

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2017 оны 04 дүгээр сарын 01-наас 2017 оны 04 дүгээр сарын 20-ныг хүртэл хийхээр төлөвлөн Төв аймгийн Аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитын багийн гишүүн аудитор, шинжээч нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2017 оны 04 дугаар сарын 01-нд төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 04 дүгээр сарын 01-наас 2017 оны 04 дүгээр сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 04 дугаар сарын 20-нд Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг дарга-д гардуулна.

1.3 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсөв

6.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг төсөвтэй байна.

6.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36 “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Төв аймгийн Засаг дарга Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл. Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан 54.2. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна, 54.3.Төсвийн

ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана.

Төсвийн тухай хуулийн 64.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 64.1.2 “тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх гэж заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг баталж байна. Мөн хуулийн 65.1 “Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 65.1.5 “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг энэ хуулийн 8.5.5-д заасан хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, Төсвийн тухай хуулийн 38.1-д Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төв төрийн сангийн дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ, 38.1.11-д нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг нэгтгэн боловсруулах гэж заасныг хэрэгжүүлэн ажиллажээ.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон СТСХэлтсийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, балансын мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын сан, биет бус хөрөнгийн дансад болон орлого, зарлагын гүйлгээнд аудитын хяналтын болон нарийвчилсан 12 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

ТЕЗ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэх үйл ажиллагаанд хэрэглэгдэх баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг улсын хэмжээнд байхгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Е-тайланд шивж нэгтгэлийн программаар нэгтгэн тайлагнасан байна. ТЕЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд 27 сумын орон нутгийн төсвийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн болон аймгийн төсвийн нийт 238 төсөвт байгууллага, 28 төрийн сан, 124 төсөл, тусгай сангууд, Орон нутгийн өмчит 3 үйлдвэрийн газар зэрэг нийт 393 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Тус албанаас Санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр төсөвт улсын төсвийн 14 байгууллага, орон нутгийн төсвийн 15 байгууллага, төрийн өмчийн ХК 1 байгууллага, 14 сумын 80 төсөвт байгууллага нийт 116 нэгж байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж мэдээллийн санг үүсгэн ажилласан байна. Шалгалтаар нийт 190.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, илрүүлсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 190.7 сая төгрөгийн акт бичиж, 78.4 хувь нь хэрэгжсэн дүнтэй байна. Шалгалтаар илэрсэн зөрчлийг ангилбал

№	Зөрчлийн ангилал	Зөрчлийн дүн	Зөрчлийн хувь
1	Албан татвар, төлбөр хураамж дутуу ногдуулсан	5024.0	2.63
2	Түрээсийн төлбөр төвлөрүүлээгүй	1020.0	0.53
3	Бусдад ашиглаж зээлдүүлсэн	587.7	0.31
4	Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	86095.0	45.13
5	Үндсэн баримтгүй болон данс бүртгэлд тусгаагүй	17188.1	9.01
6	Дутуу болон илүү олгогдсон цалин хөлс, нөхөн төлбөр	36914.7	19.34
7	Ашиглаж дутагдуулсан хөрөнгө	43698.9	22.9
8	Өр авлага үндэслэлгүй хаасан	252.0	0.15
Нийт дүн		190780.4	100.0

Мөн Төв аймгийн Засаг даргын 2016 оны 02 дүгээр сарын 04-ны А/54 тоот захирамжаар Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6-д заасныг үндэслэн төрийн сангийн 12 нэгжид дотоод хяналт хийх төлөвлөгөөг батлуулснаас 5 сумын 21 төсөвт байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалт, төрийн сангийн гүйлгээнд дотоод хяналт хийж, шалгалтын мөрөөр аймгийн Засаг даргын А/273 тоот “Төсвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамж гарган, хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан байна.

Сангийн яамны төрийн сангийн газрын дотоод хяналтаар 40 төсөвт байгууллагын 185 дансны төлбөр тооцоог эхний 9-н сарын байдлаар шалгасан байна. Үүнд ОНТСангуудын төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар баталсан төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт орлого, зарлагын дүнд оруулаагүй, ОН болон ТЗШТөсөвт байгууллагуудын санхүүжилтийг олгохдоо батлагдсан маягтыг бүрэн цогц хангалттай хийгээгүй, төсвийн гүйцэтгэлийн мэдээг ихэнх байгууллага орлогыг нэр төрлөөр нь ангилан бүртгэн оруулаагүй, орон нутгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг татварын хэлтсийн мэдээтэй тулган баталгаажуулж үнэн зөв мэдээлэл гаргаагүй, төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.5-ыг зөрчин данснаас гүйлгээ гаргахдаа засвартай төлбөрийн хүсэлтээр гүйлгээ гаргасан, зарим орлого бууруулах гүйлгээ хийхдээ орлогын дэлгэрэнгүй хуулга хавсаргаагүй, зардлыг зохих эдийн засгийн ангилалаас гаргаагүй зэрэг алдаа зөрчил илэрсэн байна.

Дээрх 3 хяналтаас дүгнэхэд санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр болон төрийн сангийн нэгжийн шалгалтыг нийт байгууллагын 60.5 хувь хамрагдаж дотоод хяналт хэрэгжүүлж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн нэгтгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУСтандартай нийцсэн байна.

Гурав. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2 заалтын дагуу Төв аймагт 222 байгууллага, аймгийн ТЭЗ болон орон нутгийн ТЭЗ 28, орон нутгийн өмчит ОНӨААТҮГГазар 3, төрийн өмчит ТӨААТҮГ 3, нийт 6 байгууллага нийт 256 байгууллага Шилэн дансны нэгдсэн портал системд хамрагдсан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт нийцлийн аудитаар 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүдийг хуулийн 6.9-д заасан төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага санхүүжилтийн мэдээллийг 88 ААНэгж, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 6 ААН байгууллагууд шилэн дансны цахим сүлжээнд байршаагүй, шилэн дансанд мэдээлэлээ байршуулах нийт 256 байгууллагаас тогтоосон хугацаанд байршуулах мэдээлэл үүнд төсвийн төслийг 72.7%, санхүүгийн хагас жилийн тайланг 47.7%, жилийн эцсийн тайланг 83.2%, аудитын дүгнэлтийг 68.7%, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг 89.8% нь мэдээлээгүй, шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, 2016 оны 4-р сард хийсэн өмнөх аудитын зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. 2016 оны 10 сард хийсэн аудитаар өгөгдсөн 184 албан хаагчдад хариуцлага тооцох албан шаардлагыг 2017 оны 2 сард бүрэн хэрэгжүүлж, СХААлбанаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтээр шалгалт хийж, үр дүнг сайжруулахаар Шилэн дансыг иж бүрэн хөтлөх сарын аян зохион байгуулж, аяны хүрээнд шилэн дансыг хөтлөх арга зүйгээр хангаж ажиллахаар төлөвлөсөн байна.

Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох

Төв аймгийн ТЭЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны санхүү үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зарлагын дүнг суурь болгон, эрсдлийг дунд гэж үнэлэн 2.0 хувиар буюу 2465.4 сая төгрөгөөр тооцлоо. Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас өөрчлөгдөөгүй болно.

Тав. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал**5.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар**

Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгөн хөрөнгө оны эхэнд 5826.4 сая төгрөгийн, оны эцэст 7659.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж, оны эхнээс 31.5 хувиар өссөн дүнтэй байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл, байгууллага, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын харилцах дансдын үлдэгдэл, кассанд байгаа бэлэн мөнгө зэргийг бүртгэж тайлагнасан. 2016 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 96.6 хувь буюу 7402.6 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн харилцах
Кассад байгаа бэлэн мөнгө	10.3	4.8	4.8	0	0
Төгрөг/ЖМС	10.3	4.8	4.8		
Банкинд байгаа бэлэн мөнгө	5816.1	7654.6	0	252.0	7402.6
Төрийн сангийн харилцах	5549.0	7402.6			7402.6
Арилжааны банк	267.1	252.0	0	252.0	
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	5826.4	7659.4	4.8	252.0	7402.6
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:					
ОН-ийн ерөнхий орлого	4157.6	4006.8			4006.8
Сумын орлогын үлдэгдэл	810.4	1156.3			1156.3
Аймгийн ерөнхий орлого	3347.2	2850.5			2850.5
Төсөвт байгууллага	0.9	0.8		0.8	
ОНӨҮГ	122.0	93.2	4.1	89.1	
Сангууд	1468.3	3550.0	0.7	162.1	3387.2
Нэмэлт санхүүжилтийн	77.5	8.6			8.6
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	5,826.3	7659.4	4.8	252.0	7402.6

2016 оны жилийн эцсийн кассын 4.8 сая төгрөгийн үлдэгдлийн 85.4 хувь буюу 4.1 сая төгрөг нь Төв Чандмань дулааны эрчим хүчний газрын үлдэгдэл эзэлж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2016 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал ОНӨО данс 4006.8 сая төгрөг, төсөвт байгууллагуудын үлдэгдэл 0.8 сая төгрөг, ОНӨҮГ-ааруудын үлдэгдэл 93.2 сая төгрөг, тусгай сангуудын үлдэгдэл 3550.0 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлсэн үлдэгдэл 8.6 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

ТЭЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7659.4 сая төгрөг буюу өмнөх оноос 1833.1 сая төгрөгөөр өссөн нь тусгай сангуудын үлдэгдэл өмнөх оноос 2081.9 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн.

Аймгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 2850.5 сая төгрөгний 312.3 сая төгрөг нь төсөвт татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө байна.

5.2 Сангуудын мөнгөн хөрөнгийн талаар.

Сангуудын мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийн бүтцийг авч үзэхэд Төрийн сангийн харилцах дансанд 3387.2 сая төгрөг, арилжааны банкин дахь харилцах дансанд 162.1 сая төгрөг, бэлэн мөнгө дансанд 0.7 сая төгрөг тус тус байршиж байна.

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн харилцах
Аймаг хөгжүүлэх сан	47.5	9.9	-		9.9
Байгаль хамгаалах сан	221.7	108.9	-		108.9
Мал хамгаалах сан	111.7	66.2	-		66.2
Орон нутгийн хөгжлийн сан	463.4	2134.4	-		2134.4
Сум хөгжүүлэх сан	471.2	1067.8	-		1067.8
Тариалан дэмжих сан	0.0	0.7	0.7		
Эмийн эргэлтийн сан	152.9	162.1	-	162.1	
Нийт дүн	1468.3	3550.0	0.7	162.1	3387.2

Тайлант онд сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2081.7 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд орон нутгийн хөгжлийн сан 1671.0 сая төгрөг, сум хөгжүүлэх сан 596.6 сая төгрөг, эм эргэлтийн сан 9.2 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

5.3 Арилжааны банкин дахь харилцах дансны талаар

2016 оны жилийн эцэст арилжааны банкин дахь харилцах дансанд 252.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Бүтцээр нь авч үзэхэд төсөвт байгууллагуудын харилцах дансны үлдэгдэл 0.8 сая төгрөг, эм эргэлтийн сангийн харилцах дансны үлдэгдэл 162.1 сая төгрөг, ОНӨҮГазрын харилцах дансны үлдэгдэл 89.1 сая төгрөг тус тус байршиж байна.

5.4 ТШЗ нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлийн талаар дурдвал:

- ✓ Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас оны эцэст зарцуулаагүй үлдэгдлийг орон нутгийн нэмэлт дансанд төвлөрүүлснийг сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд Бүрэн сум 15.4 сая төгрөгийг, Батсүмбэр сум 1.0 сая төгрөгийг, Баянцогт сум 5.1 сая төгрөг, Өндөрширээт сум 0.6 сая төгрөгийг орхигдуулан тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, Санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байсныг аудитын явцад залруулсан.
- ✓ Өндөрширээт сумын ЗДТГазар нь 2016.12.23-ний өдөр 3.5 сая төгрөгийг бэлнээр кассат авч зарцуулахдаа өвс тэжээл татах тээврийн хөлсөнд нийт 0.75 сая төгрөг олгосон дүнгээс суутгасан ашгийн татвар 0.075 сая төгрөгийг бэлэн мөнгөний тайланд давхар хасч тайлагнасан, мөн өвс тэжээлийн тооцоо бодолтыг шалгахад 1.19 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэнд төлбөрийн акт бичигдсэн.

Зургаа. Авлагын бүртгэл, тайлагнал

6.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 12187.3 сая төгрөг байснаас тайлант онд 900.7 сая төгрөгөөр буурч, оны эцэст 11286.6 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Авлагын өсөлт, бууралтыг авч үзвэл төлбөртэй үйлчилгээний авлага 10.3 сая төгрөг, байгууллагаас авах авлага 146.0 сая төгрөг, Хүмүүсээс авах авлага 516.4 сая төгрөг, бараа материал бэлтгэх урьдчилгаа 197.9 сая төгрөг, цалингийн урьдчилгаа 0.7 сая төгрөгөөр тус тус буурч, ажиллагсадтай холбоотой авлага 9.3 сая төгрөг, зээлийн хүүгийн авлага 33.8 сая төгрөг, татвар шимтгэлийн авлага 0.1 сая төгрөг, Хувь хүмүүст олгосон зээлийн авлага 244.3 сая төгрөгөөр тус тус өсчээ. Харин Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх зээл 72.5 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтцээр нь харуулбал:

(сая төгрөгөөр)

Авлагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Эзлэх хувийн жин
Ажиллагчидтай холбогдсон авлага	9.0	18.32	9.3	0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	72.8	62.5	-10.3	0.5
Зээлийн хүүгийн авлага	21.9	55.8	33.8	0.4
Татвар НДШ-ийн авлага /ТӨҮГ/		0.17	0.17	0.0
Байгууллагаас авах авлага	1202.0	1055.98	-146.0	9.4
Хувь хүмүүсээс авах авлага	8172.0	7655.6	-516.4	68.4
ЗГ-ын дамжуулан зээлдүүлэх зээлийн авлага	2427.5	2355.0	-72.5	21.0
Авлагын нийт дүн	11905.3	11203.4	-701.9	100.0
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	281.3	83.2	-197.9	
Цалингийн урьдчилгаа	0.7		-0.7	
Урьдчилгааны нийт дүн	12187.3	11286.6	900.7	

Хүснэгтээс үзвэл нийт авлага 701.9 сая төгрөгөөр буурсан. Оны эцсийн нийт авлагын, байгууллага, хүмүүсээс авах авлага 8462.3 сая төгрөг буюу 75.5 хувь, гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн 2301-МОН(SF) төслийн зээл 2071.0 сая төгрөг, 1847-МОН(SF) төслийн зээл 283.9 сая төгрөгийн зээлүүд 21.0 хувийг тус тус эзэлж байна.


Салбараар нь авч үзвэл:

(сая төгрөгөөр)

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Эзлэх хувийн жин
Боловсрол	84.77	106.81	22.0	0.94
Эрүүл мэнд	15.8	7.3	-9.0	0.06
Нийгмийн хамгаалал	0.01	2.72	2.71	0.02
Орон нутаг	11804.7	11159.1	-646.0	98.9
НИЙТ ДҮН	11905.30	11275.98	630.29	100.0

Нийт авлагын 98.9 хувь буюу 11159.1 сая төгрөгийг орон нутгийн байгууллагын авлага эзэлж байна. Үүний 73.8 хувь буюу 8.3 сая төгрөг нь сангуудын авлага эзлэж байна.

Авлагын үлдэгдлийг байгууллага тус бүрээр нь харуулбал: (сая төгрөгөөр)



6.2 ТШЗ нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлагатай холбоотой гарсан зөрчлийн талаар дурдвал:

- ✓ Сүмбэр сумын Төрийн сан дансанд үлдэгдэлтэй аймгийн 90 жилийн ойн билетийн орлого 0.95 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.
- ✓ Баянцагаан сумын ЗДТГазар авлагын дансанд оны эхэнд үлдэгдлээр байсан актлагдсан автомашины үнэ 1.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар бодитой арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- ✓ Жаргалант сумын ЗДТГазар авлагын дансанд он дамжин тайлагнагдаж байгаа 1.8 сая төгрөгийг барагдуулах талаар бодитой арга хэмжээ авч ажиллаагүй, эзэн холбогдогч нар нас барсан найдваргүй авлага үүссэн байна.
- ✓ Сэргэлэн сумын ЕБСургууль оны эцэст татварын хэлтэст илүү шилжүүлсэн татвар 2.0 сая төгрөгийн авлагатай гэж тайлагнагдсан ба харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Долоо.Бараа материалын бүртгэл, тайлагнал

7.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар

ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 5211.6 сая төгрөг, оны эцэст 5800.3 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Бараа, материал нийт дүнгээрээ өмнөх үлдэгдлээс 588.7 сая төгрөгөөр буюу 11.3 хувиар өссөн байна. Үүнд: Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын үлдэгдэл 311.5 сая төгрөгөөр буюу 9.0 хувиар, Орон нутгийн байгууллагын үлдэгдэл 208.2 сая төгрөгөөр буюу 21.0 хувиар, сангуудын болон ОНӨҮГ-ын бараа материал 68.6 сая төгрөгөөр буюу 9.3 хувиар тус бүр өссөнтэй холбоотой байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 65.4 хувийг Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага, 20.7 хувийг орон нутгийн байгууллагууд, 6.7 хувийг ОНӨҮГ, 7.2 хувийг сангуудын үлдэгдэл эзэлж байна.

Бараа материалын үлдэгдэл /Байгууллагын төрлөөр/

(сая төгрөгөөр)

Байгууллагаар	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Эзлэх хувийн жин
ОН-ийн байгууллага	990.99	1,199.21	208.22	20.67
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	3,479.91	3,791.76	311.85	65.37
ОНӨҮГ	322.20	390.76	68.56	6.74
Сангууд	418.52	418.60	0.08	7.22
НИЙТ ДҮН	5,211.62	5,800.33	588.71	100.0

Бараа материалын үлдэгдлийг багцаар авч үзвэл нийт үлдэгдлийн 2008.6 сая төгрөг буюу 34.6 хувийг орон нутгийн байгууллагын үлдэгдэл, 3791.8 сая төгрөг буюу 65.4 хувийг Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын үлдэгдэл эзэлж байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын үлдэгдлийг сайдын багцаар авч үзвэл 720.3 сая төгрөг буюу 12.4 хувь нь ЭМСайдын, 3022.0 сая төгрөг буюу 52.1 хувь нь БСУШУСайдын, 29.2 сая төгрөг буюу 0.5 хувь нь БХБЯамны ТЗШ-ийн, 20.2 сая төгрөг буюу 0.3 хувь нь ХНХСайдын багцын байгууллагын үлдэгдэл байна.

Бараа материалын үлдэгдэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	ТЗШ-ийн дүн		ОРОН НУТАГ	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
35 БАРАА МАТЕРИАЛ	3,479.91	3,791.76	1,731.71	2,008.57
35100 Түүхий эд материал	576.08	622.39	535.79	609.89
35110 Тусгай зориулалттай материал	410.86	466.04	328.25	378.33
35130 Эм боох материал	165.21	156.12	207.54	231.79
35200 Дуусаагүй үйлдвэрлэл	0.00	-	-	-
35300 Бэлэн бүтээгдэхүүн	2.11	3.00	13.40	23.00
35400 Хангамжийн материал	2,871.46	3,138.48	1,052.38	1,162.62
35410 Бичиг хэргийн материал	79.12	91.01	31.79	31.00
35420 Аж ахуйн материал	998.18	1,085.75	570.21	617.53
35430 Сэлбэг хэрэгсэл	23.30	29.84	36.30	37.48
35440 Түлш, шатах тослох материал	113.87	103.92	68.08	21.88
35450 Барилгын засварын материал	13.16	17.62	6.88	15.29
35460 Хүнсний материал	202.35	184.75	0.50	0.00
35470 Бусад хангамжийн материал	1,441.49	1,625.59	338.63	439.43
35600 Мал амьтад	30.26	27.90	130.14	213.06

Нийт дүнд эзлэх хувь	66.77%	65.37%	33.23%	34.63%
-----------------------------	---------------	---------------	---------------	---------------

Бараа материалын хөдөлгөөнийг авч үзвэл тайлант онд бараа материал нийт 12 нэр төрөлд 10381.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 9793.0 сая төгрөгөөр буурсан байна.

Үүнээс дүгнэхэд бараа материалын үлдэгдэл жилээс жилд зохих хэмжээгээр өссөөр байна.

Бараа материалын үлдэгдэл /дансдаар/


(сая төгрөгөөр)

№	Бараа материалын төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Нийт үлдэгдэлд эзлэх хувийн жин	Цэвэр өсөлт /-/, бууралт /-/
1	Тусгай зориулалттай материал	739.11	1,928.70	1,823.45	844.37	14.56%	105.26
2	Эм боох материал	372.76	1,039.08	1,023.92	387.92	6.69%	15.16
3	Дуусаагүй үйлдвэрлэл	0.00	-	0.00	-	0.00%	(0.00)
4	Бэлэн бүтээгдэхүүн	15.50	10.74	0.25	26.00	0.45%	10.49
5	Бичиг хэргийн материал	110.91	245.71	234.61	122.01	2.10%	11.10
6	Аж ахуйн материал	1,568.39	846.58	711.69	1,703.28	29.37%	134.89
7	Сэлбэг хэрэгсэл	59.59	176.40	168.67	67.32	1.16%	7.73
8	Түлш шатах тослох материал	181.95	1,923.02	1,979.17	125.80	2.17%	(56.15)
9	Барилгын засварын материал	20.03	109.04	96.16	32.91	0.57%	12.88
10	Хүнсний материал	202.85	2,845.47	2,863.57	184.75	3.19%	(18.10)
11	Бусад хангамжийн материал	1,780.12	1,108.57	823.67	2,065.02	35.60%	284.90
12	Мал амьтад	160.40	148.42	67.86	240.95	4.15%	80.55
		5,211.62	10,381.73	9,793.02	5,800.33	100.00%	588.71

Бараа, материалын үлдэгдлийг данс тус бүрээр нь авч үзвэл тусгай зориулалттай материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материалууд тус бүр 14.6-35.6 хувийг буюу нийт үлдэгдлийн 79.5 хувийг эзэлж байна.

Бараа материалын өсөлт, бууралтыг авч үзэхэд хүнсний материал, түлш шатах тослох материалууд 18.1-56.1 хувиар буурч, бусад бараа материалууд 7.7-284.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бараа, материал үлдэгдлүүдийг дансдуудаар нь авч үзвэл :



7.2 ТШЗ нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материалтай холбоотой гарсан зөрчлийн талаар дурдвал:

- Алтанбулаг, Аргалант, Баян-Өнжүүл, Баянхангай сумдууд 11.8 сая төгрөгийн бараа материалын зардлыг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн.
- Алтанбулаг, Баян, Баянчандмань, Борнуур, Сэргэлэн, Цээл сумдууд үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд буруу ангилан бүртгэж, тусгай зориулалтын материалд хөрөнгийн чанартай эд зүйлс болон малын тэжээл, нөөцийн материалд мал амьтан, сэлбэг хэрэгсэл дансанд сурах бичиг, хангамжийн материал дансанд үдийн цайны материал зэргийг бүртгэн УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн байна.
- Алтанбулаг, Архуст, Батсүмбэр, Баян, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянхангай, Банцогт, Баянчандмань, Бүрэн, Жаргалант, Мөнгөнморьт, Сүмбэр Шатахууны зарцуулалт, тооцоо бодолтын байдлыг шалгахад 93.7 сая төгрөгийн шатахууныг зарцуулахдаа тооцоо бодоогүй, олгосон дүнгээр зардалд бүртгэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, журам зөрчсөн байна.
- Алтанбулаг, Баян-Өнжүүл, Лүн, Мөнгөнморьт сумдын ерөнхий боловсролын сургуулиуд үдийн цайны болон дотуур байрны хүүхдийн хоолны зардал нормативт хэмжээнээс 5.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж Монгол улсын Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан хоолны зардлын дундаж нормативыг мөрдөж ажиллаагүй байна.
- Сумын аюулаас хамгаалах нөөцөөс малчдад өвс, тэжээл зарж борлуулахад баримтлах тусгайлан зохицуулсан журамгүй учир зарах үнийг өөрсдөө зохион, малчдад харилцан адилгүй, ялгаатай үнээр борлуулдаг байна.
- Сүмбэр сумын ерөнхий боловсролын сургууль дотуур байранд байрладаггүй хүүхэд хооллож 1.6 сая төгрөгийн хоолны зардал гаргасан, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Угтаал сумдын ерөнхий боловсролын сургуулиуд хоолны зардлын үлдэгдэл 11.9 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлэлгүй хүнсний материал худалдан авч нөөцлөсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, 6 дугаар зүйлийн 6.4.1-т төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэсэн төсвийн зарчимуудыг баримтлаагүй байна.
- Сумдуудын төсвийн байгууллагууд бараа, материал хөрөнгийн тооллогыг чанаргүй, дутуу хагас хийдэг, тооллогын бүртгэл хөтөлдөггүй, тооллого явуулсан ажлын хэсэгт хариуцлага тооцдоггүй, эд хариуцагч няравыг тооллого явуулах ажлын хэсэгт оролцуулан томилдог, тооллого тооцоог боддоггүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12, 13, 19 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 заалт, 72 дугаар зүйлийн 72.4.1 дэх заалтуудыг зөрчсөн нийтлэг зөрчил байсаар байна.

Найм.Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал**8.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар**

ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө 2015 оны эцэст 105981.3 сая төгрөг байснаас 7170.6 сая төгрөгөөр өсч, 2016 оны эцэст 113152.0 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгийн данс /байгууллагаар, цэвэр дүнгээр/

(сая.төгрөгөөр)

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
ОН-ийн байгууллага	33,705.74	35,556.20	1,850.46	31.42
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	61,366.75	66,576.65	5,209.90	58.84
ОНӨҮГ	10,692.76	10,703.53	10.77	9.46
Сангууд	216.11	315.62	99.51	0.28
НИЙТ ДҮН	105,981.36	113,152.00	7,170.64	100.00

Нийт үндсэн хөрөнгийн 31.4 хувь нь Орон нутгийн байгууллагад, 58.8 хувь нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагад, 9.5 хувь нь ОНӨҮГазарт, 0.3 хувь нь сангуудын санхүүгийн тайланд бүртгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

(сая.төгрөгөөр)

Үндсэн хөрөнгө	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Барилга байгууламж, орон сууц	83,225.08	90,967.62	7,742.54	80.39
Тээврийн хэрэгсэл	3,234.57	2,881.86	(352.71)	2.55
Машин тоног төхөөрөмж	8,527.87	8,305.16	(222.71)	7.34
Тавилга эд хогшил	3,070.46	3,084.52	14.06	2.73
Зам, гүүрийн байгууламж	1,290.35	1,284.67	(5.68)	1.14
Түүх соёлын дурсгалт зүйл	898.94	910.77	11.83	0.80
Дуусаагүй барилга байгууламж	1,241.76	1,191.75	(50.01)	1.05
Номын фонд	328.95	381.86	52.91	0.34
Бусад үндсэн хөрөнгө	3,758.36	3,746.28	(12.08)	3.31
Програм хангамж	42.26	49.44	7.18	0.04
Бусад биет бус хөрөнгө	362.76	348.07	(14.69)	0.31
ДҮН	105,981.36	113,152.00	7,170.64	100.0

Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдэл өмнөх оноос 6,8 хувиар өссөн бөгөөд хөрөнгийн 99,7 хувийг биет хөрөнгө, 0,3 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. Тухайлбал: барилга байгууламж 9,3 хувиар, тавилга, эд хогшил 0,4 хувиар, номын фонд 16,1 хувиар тус тус нэмэгдсэн бол тээврийн хэрэгсэл 10,9 хувиар, машин тоног төхөөрөмж 2,6 хувиар, дуусаагүй барилга байгууламж 4,0 хувиар, бусад биет бус хөрөнгө 4,0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Төсвийн захирагчид 2016 онд төсвийн хөрөнгөөр 712.7 сая төгрөгөөр хөрөнгө бэлдэж мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний зардалд тайлагнасныг үндсэн хөрөнгийн тодруулгын тайлан дахь хөрөнгө худалдан авсан зардалтай тулгахад зөрүүгүй байна. Хандив тусламжаар 7268.1сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн нь үндсэн хөрөнгийн өсөлтөд нөлөөлсөн байна. Мөн аймгийн ИТХурлын тогтоолоор 1224.0 сая төгрөгийн хөрөнгийг аклаж данс бүртгэлээс хассан байна.

8.2 Үндсэн хөрөнгийн тайлагналын талаар

Төв аймгийн ТЭЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар 2016 оны эхэнд анхны өртгөөр 179557.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байснаас тайлант онд нийт 20158.3 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 8221.9 сая төгрөгийн хасалт хийгдэж оны эцэст 191493.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

2016 онд нийт 20158.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдснээс 7268.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандиваар, 712.7 сая төгрөгийн хөрөнгийг худалдаж авсан, 12177.5 сая төгрөгийн хөрөнгийг бусад эх үүсвэрээс шилжүүлэн авсан байна.

Тайлант онд нийт 1289.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлт орсон байгууллагуудын хөрөнгийг нэгтгэсэн, мөн улсын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр ашиглалтад хүлээж авсан хөрөнгө тусгай шилжүүлгийн байгууллагуудад 9189.8 сая төгрөг, орон нутгийн байгууллагуудад 1930.3 сая төгрөг, ОНӨҮГазарт 732.8 сая төгрөгөөр тус тус шилжиж ирсэн хөрөнгөөр тайлагнасан байна.

ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өмнөх аудитаар өгсөн 11 сум байгууллагын 219.8 сая төгрөгийн номын фондын үлдэгдэл бусад үндсэн хөрөнгө дансанд тайлагнагдсан байгааг салгаж бүртгэх тухай зөвлөмж хэрэгжээгүй байна.

8.3 Биет бус хөрөнгийн талаар

ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Биет бус хөрөнгө оны эхэнд 511.0 сая төгрөг, оны эцэст 510.7 сая төгрөг тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгийн биет бус хөрөнгийг санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга тайлантай тулган, шалгахад 52.6 сая төгрөгөөр нэмэгдэж 47.1 сая төгрөгөөр буурсан ба үүнээс 27.0 сая төгрөгийн биет бус хөрөнгийг актлаж данс бүртгэлд тусгасан байна.

8.4 Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл

ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 2016 оны эхэнд 73537.6 сая төгрөг байсан. Тайлант хугацаанд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 7530.0 сая төгрөг, данснаас хасагдсан хөрөнгийн элэгдэл 2782.8 сая төгрөгөөр буурч оны эцэст 78338.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тайлагнагдсан байна.

8.5 ТШЗ нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлийн талаар дурдвал:

- ✓ Бүтцийн өөрчлөлтөөр нийлсэн буюу тусгаарласан байгууллагуудын хөрөнгийг шалгаж үзэхэд Солонго цогцолборын дансанд байсан 778.2 сая төгрөгийн барилга байгууламжийг данснаас хассан боловч хүлээн авах байгууллага тодорхой биш холбогдох шийдвэр тогтоолд орхигдуулсан.
- ✓ ИТХ-ын 2015 оны 85 дугаар тогтоолоор татан буугдсан Тээвэр авто замын газрын балансад бүртгэлтэй 42.3 сая төгрөгийн хөрөнгийг Аймгийн ЗДТГ-т шилжүүлснийг бүртгэлд аваагүй.
- ✓ Батсүмбэр сумын ЕБС улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БСУШУЯамнаас ирсэн судалгаатай тулган баталгаажуулахад 13.4 сая төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй.
- ✓ Батсүмбэр сумын ЗДТГ Хүүхэд залуучуудын тоглоомын талбай 6.6 сая төгрөгийн хөрөнгө орлогодоогүй, Зам гүүрийн барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдэл 3.5 сая төгрөгөөр дутуу элэгдэл байгуулсан, Барилга байгууламжийн дансанд замын постын барилга 7.1 сая төгрөг, граш склад 7.3 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгийн дансанд замын хашлага хайс 16.8 сая төгрөг, хүүхэд залуучуудын тоглоомын талбай 6.6 сая төгрөгөөр тус тус капиталжуулалгүй тус тусад нь бүртгэсэн.
- ✓ Баянцогт сумын ЗДТГ Машин тоног төхөөрөмжийн 0.72 сая төгрөгийг тавилга эд хогшилд бүртгэж, Тавилга эд хогшлын 0.003 сая төгрөгийг бусад үндсэн хөрөнгөнд бүртгэн нийт 0.723 сая төгрөгийг тайлагнасан.
- ✓ Зуунмод сумын ЗДТГазар 43 нэр төрлийн 1.6 сая төгрөгийн номыг эм боох хангамжийн материалд бүртгэн тайлагнасан.
- ✓ Эрдэнэ сумын ЗДТГазрын үндсэн хөрөнгө дансанд 0.4 сая төгрөгийн гарын авлага, ном эмхэтгэл сэтгүүл үлдэгдэлтэй байна. Нярав эд хариуцагч нь үндсэн хөрөнгийн данснаас

5.4 сая төгрөгийн актлаж хассан материалын тайланг хийгээгүй, ня-бо санхүүгийн программд шийдвэрийн дагуу хассан. Тооллогын комисс тооллогын бүртгэлд чанар байдал бичээгүй, дүнг дүгнээгүй, ня-бо тулган тооцоо бодоогүй.

- ✓ Өндөрширээт сумын ЕБСургууль нь ОНХСангийн эх үүсвэрээр хийгдсэн сургуулийн барилгын цонх засварын ажлыг хүлээн авсан акт баримтгүйгээр 29.9 сая төгрөгөөр хандив гэж бүртгэсэн. Тоног төхөөрөмж дансанд 8.7 сая төгрөгийн, Эд хогшил дансанд 5.0 сая төгрөг нийт 13.7 сая төгрөгийн хөрөнгийг ямар ч анхан шатны баримтгүйгээр бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэрийг тоног төхөөрөмж, эд хогшил гэж бичиж орлогодсон. Үндсэн хөрөнгийн тооллого явуулах комисст няравыг томилсон, тооллогын комисс нь тооллогын үр дүнг бичиж, хэлэлцүүлсэн материал байхгүй, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүнг үндэслэн тооцоо бодоогүй байна.

Ес.Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

9.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар

/ сая төгрөг/

Өглөг салбараар	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Боловсрол	649.8	21.0	-629.0
Эрүүл мэнд	5.3	5.2	-0.1
Нийгмийн хамгаалал	68.7	0.1	-69.0
Батлан хамгаалах	0.8	0.8	
Орон нутаг	1609.1	708.8	-901.0
Богино хугацаат өглөгийн дүн	2333.9	735.2	-1599.1
Засгийн газрын дамжуулан зээлдүүлсэн зээл	2417.5	2355.0	
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/		440.5	440.5
Урт хугацаат зээлийн дүн	2417.5	2795.5	440.5
<u>НИЙТ ДҮН</u>	<u>4751.4</u>	<u>3530.7</u>	<u>-1230.7</u>

Нийт өр төлбөрийн 2355.0 сая төгрөг буюу 66.7 хувь нь Гадаадын зээлийн хөрөнгийг Азийн хөгжлийн банкаар дамжуулан зээлдүүлсэн МОН-2301 төслийн зээлийн өр, бусад урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

Богино хугацаат авлага өмнөх оноос 1598.7 сая төгрөг буюу 69.0 хувиар буурсан байна. Үүнээс Аймгийн засаг даргын А/719 тоот захирамжаар БСШУЯамны сайдын багцад төсвийн зохицуулалт хийн 629.0 сая төгрөгөөр буурсан, А/716 тоот захирамжаар орон нутгийн байгууллагууд, өрхийн эмнэлэгт 66.2 сая төгрөг өр барагдуулахаар шийдвэрлэсэн байна.

9.2 ТШЗ нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар өглөгтэй холбоотой гарсан зөрчлийн талаар дурдвал:

- ✓ ОНӨГ-Худалдан авах ажиллагааны албаны 0.39 сая төгрөгийн шуудан холбооны зардлын өглөгийг санхүүгийн тайланд шилжүүлэн бүртгэж аваагүй
- ✓ Сумдын төсөвт байгууллагууд төрийн сангийн хуулганаас зөрүүтэй өр авлагыг мэдээлдэг байдал нийтлэг илэрч байна. Энэ нь төсвийн тайлан бүлэгтэйд тайлагнагдсан хүлээгдэж буй гүйцэтгэлд гэсэн баганад байгаа өр авлагыг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тохируулахад зөрүүтэй байгаад анхаарч мэдээний үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Арав. Орлогын бүртгэл, тайлагнал

10.1 Мөнгөн гүйлгээний тайлангийн орлогын талаар

ТЭЗахирагчийн 2016 оны мөнгөн гүйлгээний тайлангаар нийт орлого 113595.5 сая төгрөгөөр тайлагнагдсан ба өмнөх онтой харьцуулахад 4881.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант оны орлогын бүтцийг авч үзвэл татварын орлого 12997.7 сая төгрөг, татварын бус орлого 22010.6 сая төгрөг, тусламж санхүүжилтийн орлого 78587.2 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

10.2 Төсвийн орлого, санхүүжилтийн талаар

Төв аймгийн 2016 оны төсвийн орлого, эх үүсвэрийг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас 74707.4 сая төгрөгөөр баталсан.

Төсвийн орлого эх үүсвэр /сая төгрөг/

Орлого, тусламжийн төрөл	Аймгийн ИТХурлын хуралдааны			Сумдын ИТХ-ын тогтоол	Нийт орлого, эх үүсвэр
	2015.12.04-ны 09 тоот тогтоол	2016.03.23-ны 05 тоот тогтоол	2016.10.14-ны 02 тоот тогтоол		
татварын орлого	10,059.30	10,059.30	10,105.10	2,120.20	12,225.30
татварын бус орлого	221.6	221.6	221.6	314.7	536.3
Өмнөх оны төсвийн хэмнэлт			777.5		777.5
УТ-ийн санхүүгийн дэмжлэг	8,913.30	8,913.30	8,841.00		8,841.00
ОНХС-ийн шилжүүлэг	6,679.80	6,679.80	6,300.90		6,300.90
ТЗШ	40,242.80	40,242.80	40,606.10		40,606.10
Төсвийн шилжих үлдэгдэл		3,346.40	2,568.90	649.3	3,218.20
ОНХС-ийн шилжих үлдэгдэл		93.6	93.6	355.9	449.5
ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого	59.4	59.4	69.4		97.8
Тогтоолоор баталсан орлогын дүн	66,176.20	69,616.20	69,584.10	3,440.10	73,052.60
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх			182.8	1,472.00	1,654.80
Нийт орлогын дүн	66,176.20	69,616.20	69,766.90	4,912.10	74,707.40

Төв аймгийн ТЭЗ нь 2016 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг батлагдсан төлөвлөгөөгөөр 8841.0 сая төгрөг, ОНХСангийн орлогын шилжүүлэг 6300.9 сая төгрөгөөр батлагдсанаас санхүүжилтээ бүрэн авсан. Тусгай зориулалтын шилжүүлэг төлөвлөгөөгөөр 40606.1 сая төгрөг авахаас, гүйцэтгэлээр 40608.8 сая төгрөг авч, 2.7 сая төгрөгөөр тус тус илүү санхүүжигдсэн байна.

10.3 Татварын болон татварын бус орлогын талаар

Төв аймгийн төсөвт төвлөрөх 2016 оны татварын буюу урсгал орлогыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 дугаар сарын 04 ний өдрийн 11-р хуралдааны 09 тоот тогтоолоор татварын буцаан олголтыг хассанаар 10280.9 сая төгрөгөөр баталсан.

Татварын орлогын 2016 оны төлөвлөгөөнд аймгийн ИТХ-ын хуралдаанаар 1 удаа тодотгол хийгдсэн байна. Үүнд:

- Төв аймгийн ИТХурлын 2016 оны 10-р сарын 04-ны өдрийн 2-р хуралдааны 02 тоот тогтоолоор хувь хүний орлогын албан татварын буцаалтыг 45.7 сая төгрөгөөр бууруулж, 2016 оны батлагдсан татварын буцаан олголтыг хассанаар татварын урсгал орлогыг 10326.6 сая төгрөгөөр тодотгон баталсан

Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас орон нутгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 2434.9 сая төгрөгөөр баталснаар 2016 оны аймгийн урсгал төсвийн орлого нийт 12761.6 сая төгрөгөөр батлагдсан байна.

2016 оны аймгийн урсгал төсвийн орлого гүйцэтгэлээр 15115.4 сая төгрөг, үүнээс татварын буцаан олголт 704.2 сая төгрөгийг хасч тооцоход 14411.2 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөөг 112.9 хувиар буюу 1650.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 16 нэр төрлийн орлогын төлөвлөгөө биелэж, үйл ажиллагааны орлогын татвар, бууны татвар, улсын тэмдэгтийн хураамж, ТТАМАТөлбөр, үндсэн хөрөнгө борлуулсны орлого, ойгоос түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр, өмч хувьчлалын орлого зэрэг нь 8.8-39.0 хувиар тасарсан байна.

- Сумын орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын төлөвлөгөө 2434.9 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 2995.0 сая төгрөг буюу 123.0 хувиар биелүүлсэн. Сумдаар нь авч үзвэл 15 сум 100.1-222.5 хувиар биелүүлж, Батсүмбэр, Баян, Баянжаргалан,

Баянхангай, Баянцогт, Борнуур, Дэлгэрхаан, Заамар, Угтаал, Сүмбэр, Цээл, Эрдэнэ сумд 5.0- 47.1 хувиар тасалсан.

- Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлого төлөвлөгөөгөөр 10326.7 сая төгрөг, гүйцэтгэлээр 11370.5 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөөг 1043.8 сая төгрөг буюу 110.1 хувиар биелүүлсэн байна. Аймагт төвлөрөх орлогыг 12 сум 100.8-213.7 хувиар биелүүлж, 15 сум 1.1-39.0 хувиар тасалсан байна.
- Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 4658.3 сая төгрөг, гүйцэтгэлээр 6404.2 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 137.0 хувиар биелүүлсэн байна. 18 сум 102.6 -242.3 хувиар биелүүлж, 9 сум 9.7 – 60.8 хувиар тасалсан байна.

2016 оны татварын ба татварын бус орлогын бүтэц

/сая.төгрөг/

орлогын нэр төрөл	Аудитлагдсан дүн		татварын хэлтсийн мэдээгээр		санхүүгийн тайлангаар		татварын орлогын гүйцэтгэлийн зөрүү	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	аудитлагдсан тайлан, татварын мэдээний	аудитлагдсан тайлан санхүүгийн тайлангийн
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	6,724.3	6,769.5	6,724.3	6,768.3	6,724.3	6,769.5	1.2	-
Мал бүхий иргэний орлого	-	0.9	-	0.9	-	0.8	-	0.1
Үйл ажиллагааны ОАТ	587.8	358.7	587.8	358.7	587.8	382.1	-	(23.4)
Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар	184.9	363.5	184.9	363.5	184.9	353.8	-	9.7
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	281.9	445.6	281.9	445.6	281.9	445.7	-	(0.1)
АТБӨЯХэрэгслийн татвар	270.0	336.0	270.0	316.5	270.0	336.0	19.5	-
Бууны албан татвар	30.8	28.1	30.8	28.1	30.8	28.1	-	-
Улсын тэмдэгтийн хураамж	292.1	276.0	292.1	276.0	292.1	275.3	-	0.7
Газрын төлбөр	1,482.4	1,661.0	1,482.4	1,659.0	1,482.4	1,661.0	2.0	-
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (Алтны нөөц)	13.4	39.3	13.4	39.3	13.4	39.8	-	(0.5)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	193.0	184.7	193.0	184.7	193.0	185.6	-	(0.9)
Ус ашигласны төлбөр	1,414.7	1,841.5	1,414.7	1,838.5	1,414.7	1,841.5	3.0	-
Агнуурын нөөц ашигласны	185.1	331.0	185.1	299.0	185.1	331.0	32.0	-
Ойгоос түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр	215.2	151.9	215.2	152.1	215.2	151.9	(0.2)	-
Байгалийн ургамал ашигласны төлбөр	127.0	455.6	127.0	455.6	127.0	455.6	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	147.2	114.8	147.2	114.8	147.2	114.8	-	-
Түрээсийн төлбөр	23.2	37.5	23.2	37.5	23.2	37.5	-	-
Хүү торгууль	690.2	823.2	690.2	820.1	690.2	823.2	3.1	-
Нэр зааж ангилагдаагүй орлого	275.6	583.6	275.6	586.8	275.6	586.8	(3.2)	(3.2)
нохойны татвар	1.0	1.5	1.0	1.5	1.0	0.8	-	0.7

хог хаягдал	168.3	181.9	168.3	181.9	168.3	168.4	-	13.5
өмч хувьчлалын орлого	64.4	22.7	64.4	22.7	64.4	21.7	-	1.0
ТБӨОрлого	92.8	106.9	92.8	105.0	92.8	106.9	1.9	-
Дүн	13,465.3	15,115.4	13,465.3	15,056.1	13,465.3	15,117.8	59.3	(2.4)
Буцаан олголт	704.2	704.2	704.2	(704.2)	704.2	(704.2)		
Татварын буцаан олголт хассан дүн	12,761.1	14,411.2	12,761.1	14,351.9	12,761.1	14,413.6		

Төв аймгийн Татварын хэлтсийн 2016 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн мэдээгээр аймгийн төсөвт төвлөрсөн орлогын мэдээ нь төрийн сангийн харилцах дансны хуулгын дүнгээс зөрүүтэй мэдээлэгдсэн байна. Үүнд:

- Нэр зааж ангилаагүй орлого дансанд 159.1 сая төгрөг орсон байхад 126.8 сая төгрөгөөр мэдээг гаргаж, 32.3 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн.
- Цэргийн дүйцүүлэх албаны дансанд орсон 47.7 сая төгрөгийг орлогоор огт мэдээлээгүй
- АТБӨЯХТатварын орлого 336.0 сая төгрөг орлогын дансанд орсон байхад 19.5 сая төгрөгөөр дутуу буюу 316.5 сая төгрөгөөр мэдээлсэн байна. Энэ нь гадны дугаар бүхий авто машины тээврийн хэрэгсэлийн татварыг хасч тооцсонтой холбоотой байна.

10.4 Тусламж, санхүүжилтийн орлогын талаар

Тусламж, санхүүжилтийн орлогод улсын төсвийн санхүүжилтийн орлогод 8841.0 сая төгрөг, ОНХСангийн шилжүүлэг 6300.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 40608.8 сая төгрөг, төсвийн захирагчдаас 160.7 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 1910.8 сая төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилт 27842.3 сая төгрөг, нийт 78587.1 сая төгрөгийн орлого бүртгэгдсэн. Тусламж, санхүүжилтийн орлого өмнөх оноос 5538.8 сая төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант оны нийт тусламж, санхүүжилтийн орлогын 62.1 хувь буюу 48820.5 сая төгрөг нь улсын төсвийн санхүүжилтийн орлого эзэлж байна.

10.5 ТШЗ нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар орлоготой холбоотой гарсан зөрчлийн талаар дурдвал:

- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 77 дугаар тогтоолоор тооцсон Газрын дуудлага худалдааны анхны үнийн орлогыг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэлгүйгээр сумын ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн данс, ОНХСанд төвлөрүүлсэн байна. Үүнд :
 - ✓ Баянчандмань сум нь 1.5 сая төгрөгийг ОНХСангийн дансанд
 - ✓ Цээл сум нь 16.6 сая төгрөгийг ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансанд
 - ✓ Аргалант сум нь 4.8 сая төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд
 - ✓ Өндөрширээт сум 2.3 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн санд
 - ✓ Эрдэнэ сум 17.2 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн санд
 - ✓ Алтанбулаг сум 6.7 сая төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд тус тус төвлөрүүлсэн байна.
- Баян сум нь сумын төсвийн орлогод хамаарах төрийн албан хаагчийн орон сууцны түрээсийн орлогын 1.1 сая төгрөгийг орон нутгийн татварын орлогын дансанд оруулалгүй сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтын дансанд оруулсан.
- Сэргэлэн сум төлөвлөгөөгүй шонхорын орлого 140.8 сая төгрөг, Баянцагаан сум 12.0 сая төгрөгийн шонхорын орлогын төлөвлөгөөтэй боловч 43.6 сая төгрөг төвлөрүүлсэн. Баянцагаан сум нь шонхорын орлогоос бусад орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй.
- Төв аймгийн төрийн санд байршдаг татварын бус орлого-14000914 тоот дансанд 3.7 сая төгрөгийн ХХОАТ-ын орлогын гүйлгээ, 1.5 сая төгрөгийн залруулах гүйлгээ хийгдсэн, бусад татвар хураамж -14000947 тоот дансанд хог хаягдлын хураамжийн

0.59 сая төгрөгийн орлогын гүйлгээ, 0.24 сая төгрөгийн залруулах гүйлгээ хийгдсэн, газрын ҮХЭХАТ-140000923 тоот дансанд газрын ҮХЭХАТатвар 0.59 сая төгрөгийн орлогын гүйлгээ хийгдсэн байна.

Арван нэг. Зардлын бүртгэл, тайлагнал

11.1 Зардлын бүтцийн талаар

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12-р сарын 04-ний өдрийн 11-р хуралдааны 09 тоот тогтоолоор Төв аймгийн 2016 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 66176.2 сая төгрөгөөр баталсан байна.

2016 оны Төсвийн зарлагын хэмжээг 2016 оны 03-р сарын 23-ний 05 тоот тогтоолоор 69616.2 сая төгрөгөөр, 2016 оны 10-р сарын 14-ний 02 тоот тогтоолоор 69584.1 сая төгрөгөөр тус өөрчлөн тодотгосон. Мөн сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаас урьд оны шилжих үлдэгдэл болон орлогоос 4912.1 сая төгрөг нэмж тодотгон баталсан ба Сангийн яамнаас 2016 онд зарцуулах төсвийн зарлагыг нийт 74707.4 сая төгрөгөөр хянаж баталгаажуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага батлагдсан төлөвлөгөөгөөр 74707.4 сая төгрөг, гүйцэтгэлээр 70188.1 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөнөөс 4519.3 сая төгрөг дутуу зарцуулсан буюу биелэлт 93.9 хувь байна. Нийт зарлага өмнөх оноос 5039.7 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт зардлын бүтцийг эдийн засгийн ангилалаар харуулбал / сая төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	өмнөх үеэс өсөлт /+/, бууралт -/	гүйцэтгэлд эзлэх хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65148.4	74707.4	70180.5	5032.1	100.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	30884.5	30879.0	30659.1	-225.4	43.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3380	3405.9	3347.7	-32.3	4.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6688.7	9090.6	8923.3	2234.6	12.7
Хангамж, бараа материалын зардал	853.9	1037.1	1021.3	167.4	1.5
Нормативт зардал	2768	3101.4	3035.2	267.2	4.3
Эд хогшил, урсгал засварын зардал	208.4	218.0	219.6	11.2	0.3
Томилолт, зочны зардал	199.4	142.7	132.3	-67.1	0.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	352.4	887.5	824.3	471.9	1.2
Бараа үйлчилгээний бусад зардал	2774.8	6843.9	6598.4	3823.6	9.4
Хүү	44	0.0	0.0	-44.0	0.0
ТАТААС	123.1	377.9	377.9	254.8	0.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7656	9810.5	8633.6	977.6	12.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9215.3	7233.2	5139.1	-4076.2	7.3
Эргэж төлөгдөх зээл		1679.7	1268.9	1268.9	1.8

Дээрх хүснэгтээр харахад нийт зарлагын 90.3 хувийг дараах 5 зардал эзэлж байна. Үүнд:

- Цалин хөлс, ажил олгогчоос олгох зардал нийт зарлагын 48.5 хувь буюу 34006.8 сая төгрөгийг,
- Хөрөнгийн зардал нийт зарлагын 7.3 хувь буюу 5139.1 сая төгрөгийг,
- Бараа үйлчилгээний бусад зардал нийт зардлын 9.4 хувь буюу 6598.4 сая төгрөгийг,
- Урсгал шилжүүлэг буюу нийгэм халамжийн зардал нийт зардлын 12.3 хувь буюу 8633.6 сая төгрөгийг,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал нийт зардлын 12.7 хувь буюу 8923.3 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

Өмнөх оноос байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2234.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 3536.5 сая төгрөг, урсгал шилжүүлэг 1010.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Өссөн шалтгааныг тодруулахад:

- ✓ Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоолоор дулааны өртгийг нэмсэнтэй холбогдуулан ЕБС-иудын халаалтын зардалд 608.5 сая төгрөг, цэцэрлэгүүдийн халаалтын зардалд 95.5 сая төгрөг, соёлын төвүүдийн халаалтын зардалд 459.8 сая төгрөг, нам даралтын уурын зуухтай бусад сумдын сургууль, цэцэрлэг, соёлын төвүүдийн халаалтын зардалд нэг тн нүүрсний үнэ, тээврийн зардлын үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 416.8 сая төгрөг, нийт 1580.6 сая төгрөгөөр өмнөх оны халаалтын зардлаас өссөн байна. Мөн Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоолоор ЕБС-иудын цэвэр бохир усны зардалд 35.7 сая төгрөг, цэцэрлэгүүдийн цэвэр бохир усны зардалд 18.7 сая төгрөг, нийт 54.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- ✓ Орон нутгийн төсөвт бараа үйлчилгээний зардалд орон нутгийн шилжих үлдэгдлээр санхүүжигдэх зардлуудыг төлөвлөсөн байгаа ба 2015 оны гүйцэтгэлээс нэмэгдсэн. 2016 оны шилжих үлдэгдэл аймагт 3364.4 сая төгрөг, суманд 649.3 сая төгрөгөөр тус тус төсөвт тусгагдан зарцуулагдсан байна.

Төсвийн тухай хуулийн 54.5.1-д тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/ гэсэн бүрэлдэхүүнтэй байхаар заасан ба ТЕЗ-ийн санхүүгийн тайланд ашиглагдаж буй е-тайлангаас эдийн засгийн ангилалаар шивдэг тул хөтөлбөр төсөл арга хэмжээгээр орлого зарлагын гүйцэтгэл гардаггүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн захирагчаар авч үзэхэд нийт зарцуулалтын 44.1 хувийг буюу 30921.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын багц, 45.3 хувийг буюу 31810.1 сая төгрөгийг БСШУЯамны багц, 9.9 хувийг буюу 6957.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн багц эзэлж байна. Өмнөх оноос Аймгийн засаг дарга 2402.5 сая төгрөгөөр, БСШУС 3534.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, БХБС-ийн багц 13.6 сая төгрөгөөр, ХНХСайдын багц 9,8 сая төгрөгөөр, ЭМС-ын багц 374.0 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг төсвийн захирагчаар харуулбал /сая төгрөгөөр/

Сайдын багцаар	2015 он				2016 он				өсөлт бууралт	
	төлөвлөгөө	гүйцэтгэл	Эзлэх хувь	Төсвийн хэмнэлт/+/- хэтрэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	Эзлэх хувь	Төсвийн хэмнэлт/+/- хэтрэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл
Аймгийн Засаг дарга	31608.4	28656.9	44	2951.5	34,010.9	30,921.0	44.1	2,884.6	-2,402.5	-2,264.1
БСУШУСайд	29578.9	28640.9	44	938	33,113.3	31,810.1	45.3	1,534.9	-3,534.4	-3,169.2
БХБСайд	244.4	240.2	0.4	4.2	230.5	230.4	0.3	0.1	13.9	9.8
ХНХСайд	288.2	278.9	0.4	9.3	277.6	269.1	0.4	8.5	10.6	9.8
ЭМСайд	7598	7331.5	11.3	266.6	7,075.1	6,957.5	9.9	91.2	522.9	374.0
ДҮН	69317.9	65148.4	100	4169.5	74,707.4	70,188.1	100.0	4,519.3	-5,389.5	-5,039.7

11.2 Зардлын тайлагналын талаар

Төв аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан 70188.1 сая төгрөгийн зарцуулалттай тайлагнагдсан нь өмнөх оноос 5886.9 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт зарлагыг харьцуулан харуулбал /сая төгрөгөөр/

Зардал	Тайлангийн хугацаа	Санхүүгийн үр дүнгийн тайлан	Мөнгөн гүйлгээний тайлан	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
	өмнөх он	113772.3	101436.9	76075

Нийт зардал	тайлант он	112268.7	111762.4	70188.1
	зөрүү	1503.6	-10325.5	5886.9

Төв аймгийн ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайланг е тайлан болон төсвийн хэлбэлзэлтэй тулгахад батлагдсан төлөвлөгөө 202.2 сая төгрөгөөр зөрүүтэй гүйцэтгэл 7.6 сая төгрөгөөр зөрүүтэй татагдаж тайлагнагдсан байна.

Үзүүлэлт	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	
	төлөвлөгөө	Гүйцэтгэл
Е-тайлан	74504.9	70180.5
төсвийн хэлбэлзэл	74707.1	70188.1
Зөрүү	202.2	7.6

11.3 ТШЗ нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардалтай холбоотой гарсан зөрчлийн талаар дурдвал:

- ✓ Биеийн тамир спортын газар нь аймгийн Засаг даргын 2016.12.19-ний өдрийн А/694, А/695 дугаар захирамжуудыг үндэслэн түлш халаалтын зардлын хэмнэлтээс 35.5 сая төгрөгийг спортын ордны тааз, хана, цахилгааны монтажны их засварт зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 24.4-д “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн, мөн Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5.3-т заасан “аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь төсвийн байгууллагаас ирүүлсэн 10.0 сая төгрөг хүртэлх зохицуулалт хийх хүсэлтийг судлан, зөвшөөрөгдсөн зардлын бүлэг хооронд зохицуулалтыг хийж, бүртгэн баталгаажуулна” гэснийг зөрчин эрх мэдлээ хэтрүүлэн ажилласан байна.
- ✓ Баян сум нь ОНХС-аас 12.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан. Аймгийн шүүхийн 2016 оны 03-р сарын 10-ны өдрийн 151/ШШ2016/00203 тоот шийдвэрээр иргэн Б.Болдбаатарт төлөх газрын төлбөр 12.0 сая төгрөгийг сумын ЗДТГ-аар төлүүлэх шийдвэр гарсан байна. Уг төлбөрийг 2016 оны 09-р сарын 15-ны өдрийн сумын Засаг даргын “Зардал гаргах тухай” а/274 тоот захирамжаар сумын ОНХС-аас гаргахыг шийдвэрлэж, 2016 оны 10-р сарын 07-ны өдөр Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж авлага үүсгэсэн.
- ✓ Мөнгөнморьт сумын ЗДТГ нь 2017 оны 2 дугаар улирлаас хэрэгжүүлж эхлэх цөлжилтийн эсрэг арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхээр 2016 оны эцэст “Газарзүй, гео-эко хүрээлэн”-д 5.0 сая төгрөг шилжүүлж, авлага үүсгэсэн.
- ✓ Алтанбулаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 7 дахь удаагийн сонгуулиар шинээр сонгогдсон ИТХ-ын дарга болон сумын ИТХТэргүүлэгч Д.Батсуурийн уран бүтээлийн тоглолтонд хүндэтгэл үзүүлж тус бүр 0.26 сая төгрөгийн үнэтэй мөнгөн аяга бэлэглэсэн, Баян-Өнжүүл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тушаал шийдвэргүй, нэхэмжлэхээс өөр ямар ч анхан шатны баримтгүйгээр 1.0 сая төгрөгөөр 5 ширхэг мөнгөн аяга авч зардалд бичин, нийт 1.5 сая төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан.
- ✓ Орон нутгийн Халамжийн сан нь Төрийн сангийн данснаас арилжааны банкин дахь харилцах дансруу шилжүүлсэн халамжийн мөнгөний зарцуулалтыг тухай бүр хянаж, зарцуулдаггүй, үлдэгдлийг тодорхой хугацааны эцэст төрийн сангийн дансанд татан төвлөрүүлж, төсвийн орлого, зардлын гүйлгээг тохируулдаггүйгээс нийгмийн халамжийн сангийн Төрийн сангийн хуулгаарх орлого, зардлын гүйцэтгэл, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлого, зарлагын гүйцэтгэл 91.4 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

- ✓ Баянцагаан сумын ИТХ нь тайлант онд бараа үйлчилгээний бусад зардлаас 4.1 сая төгрөгийг Хюман капитал ХХК-ны дансанд шилжүүлэн туршлага судлах нэрээр БНХАУ-ын Манжуур хотод 16 хүн аялалаар явсан байна.
- ✓ Баян-Өнжүүл суманд Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд зарцуулсан 19.2 сая төгрөгийн ажил гүйлгээнд ажил гүйцэтгэх гэрээ, гэрээ дүгнэсэн акт хавсаргаагүй байна.

11.4 Хуваарилагдаагүй, шилжих үлдэгдэл, төсвийн хэмнэлтийн зарцуулалтын талаар

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 12-р сарын 04-ны өдрийн 11-р хуралдааны 09 тоот “Аймгийн 2015 оны төсөв батлах тухай”, 2016 оны 10-р сарын 14-ний өдрийн 02 тоот “Аймгийн 2016 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор ахмадын байгууллагын санхүүгийн дэмжлэгт 57.8 сая төгрөг, албан журмын даатгалд 27.0 сая төгрөг, Төв Чандмань ДЭХГазарт усан хангамжийн татаас санхүүжилтэнд 102.0 сая төгрөг, дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрт 80.9 сая төгрөг, нийтийн гудамжны гэрэлтүүлэг буюу Төв шинэчлэл УУГазрын санхүүжилтэнд 126.3 сая төгрөг, мал эмнэлгийн үйлчилгээнд 421.3 сая төгрөг, ангилагдаагүй зардалд 211.4 сая төгрөг, орон нутгийн чанартай автозамын засвар үйлчилгээнд 304.0 сая төгрөг, 2015 оны жилийн эцсийн аймгийн орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлийг 3346.4 сая төгрөгөөр баталж, төсвийн хэмнэлт, урамшуулалд 777.5 сая төгрөг, хөрөнгийн зардалд 2568.9 сая төгрөг нийт 4677.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөгөө батлагдсан.

Төрийн сангийн 140051000 тоот харилцах дансаар дээрх батлагдсан төсвийн зардлыг зарцуулсан ба харилцах дансны хуулгыг оны эхнээс боловсруулж тайлагнаж байгаагүй нь зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг тулган шалгахад хүндрэлтэй байлаа. Төсвийн е-тайлангийн бүлэгтэй төсвийн гүйцэтгэлээр 4687.0 сая төгрөгийн зарлагын гүйцэтгэлтэй байна.

Бүртгэлийн дансны хуулгаар гаргасан зарлагын гүйлгээг аудитын явцад түүвэрлэн тулган шалгахад дараахь зөрчил дутагдал илэрлээ.

1. 2014-2015 онд хийгдсэн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэж, тусгаагүй, аймгийн ИТХ-ын хуралдаанаас 2015 оны шилжих үлдэгдлийг баталсан төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 126.6 сая төгрөгийг 2015 оны шийдвэрээр шилжүүлсэн. Үүнд:

- 2016 оны 01-р сарын 22-ний өдөр Батсүмбэр сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд мөнгөн хөрөнгө зарцуулах шийдвэр байхгүй, зөвхөн 2015 оны 11-р сарын 13-ний санхүүжилтийн мэдэгдэл, харилцагч байгууллагын хүсэлт албан бичгийн дагуу Модон гүүр барих ажлын санхүүжилтэнд 8.0 сая төгрөгийг шилжүүлсэн.
- Эйблсофт компанид 2016 оны 01-р сарын 22-ний өдөр Able системийн ашиглалт үйлчилгээний төлбөрт 5.7 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2015 оны 11-р сарын 11-ний өдрийн № А/497 тоот захирамжаар төсвийн хэмнэлт шилжих үлдэгдлээс зарцуулах шийдвэрээр шилжүүлсэн.
- 2015 онд Зуунмод сумын Баянхошуу багийн үйлчилгээний төвийн ус түгээх байранд автомат ус түгээх систем суурилуулсан 9.9 сая төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын 2016 оны 01-р сарын 25-ний өдрийн №А/16 тоот захирамжаар төсвийн хэмнэлт шилжих үлдэгдлээс санхүүжүүлэх шийдвэрээр шилжүүлсэн.
- 2016 оны 01-р сарын 27-ний өдөр Төв АЗЗА ХК-д 2015 оны өвлийн арчлалтын зардал гэж 11.8 сая төгрөгийг шилжүүлсэн.
- 2016 оны 01-р сарын 29-ний өдөр Төв Чандмань ДЭХГазарт 59.9 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2016 оны 01-р сарын 29-ний №А/23 тоот захирамжаар урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх гэсэн шийдвэрээр шилжүүлсэн. Энэ нь аймгийн Засаг даргын 2014 оны 09-р сарын 03-ний өдрийн №А/424 тоот захирамжаар Төв Чандмань ДЭХГазарт нь өөрийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 79.9 сая төгрөгөөр Зуунмод сумын 5-р багийн нутагт шинээр баригдсан 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын цэвэр бохир, дулааны шугам сүлжээг хийсэн байна.

- Гааг маркетинг ХХК-д 2016 оны 03-р сарын 11-ний өдөр гэрээт ажлын үлдэгдэл төлбөр гэж 1.7 сая төгрөгийг мөнгөн хөрөнгө зарцуулах шийдвэр байхгүй, 2015 оны нэхэмжлэхээр шилжүүлсэн
 - Төв аймгийн Нийгмийн халамжийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 2016 оны 02-р сарын 26-ний өдөр 29.6 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2015 оны 12-р сарын 25-ний өдрийн №А/566 тоот захирамжаар аймгийн халамжийн сангийн 2015 оны батлагдсан төсвийн хэмнэлтээс санхүүжүүлэх шийдвэрээр шилжүүлсэн гэх мэт
2. Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний он дамжсан үлдэгдэл санхүүжилтийг санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй ба түүнийг хэд хэдэн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр баталж байгаа нь түүний зарцуулалтыг нотлох боломжгүй байна. Тухайлбал:
- ✓ Төв аймгийн Зуунмод сумын халаалтын 6-р зуухны барилга угсралт инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэлээр үлдэгдэл санхүүжилт 548.4 сая төгрөг гэж гүйцэтгэлийг Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн хүлээн авч хянасан. 2016 онд үлдэгдэл санхүүжилтийг аймгийн 2015 оны шилжих үлдэгдлээс 321.4 сая төгрөг, аймгийн ОНХСангийн эх үүсвэрээс 250.0 сая төгрөг нийт 571.4 сая төгрөг буюу 23.0 сая төгрөгийг илүү баталсан байна. Гүйцэтгэлээр аймгийн ОНХСангийн харилцах данснаас 2 удаагийн шилжүүлгээр 250.0 сая төгрөг, аймгийн шилжих үлдэгдлээс 3 удаагийн шилжүүлгээр 301.4 сая төгрөг нийт 551.4 сая төгрөгийг олгож уг ажлын гүйцэтгэлээс 3.0 сая төгрөгийг илүү олгосон нь зохиогчийн хяналтын зардалд шилжүүлсэн байна.
3. Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн 79.7 сая төгрөгийг бэлнээр авч зарцуулсан. Бэлэн мөнгөний тайлан зарцуулалтыг шалгахад мөнгөн кассын нярав нь бэлэн мөнгийг тухайн мөнгийг зарцуулах төсөв хийсэн албан тушаалтнууд авч өгдөг ба өмнөх онуудад гарч байсан мөнгөн хөрөнгийн зарцуулалт, баталгаажуулалт, санхүүгийн сахилга, хариуцлагатай холбоотой анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн зэрэг зөрчил давтагдсаар байна. Тухайлбал:
- ✓ Аймгийн Засаг даргын 2016 оны 07-р сарын 01-ний өдрийн №А/370 тоот тушаалаар сумдын санхүүгийн албаны дарга, ня-бо нарт төсвийн төлөвлөлт, тайлагналын сургалтанд 1.8 сая төгрөг зарцуулах шийдвэр гарсаны дагуу 1.2 сая төгрөгийг 07-р сарын 4-нд бэлэн мөнгөөр авсан. Зарцуулалт нь 2016.07.26-нд Шуудан үйлчилгээний газраас 0.18 сая төгрөгийн дэвтэр бал, Өгөөж миний маркетаас 2016.07.26-нд 0.15 төгрөгийн кафе цайны баримт, 2016.08.28-ний өдөр Самата хоолны газрын 0.9 сая төгрөгийн хоолны баримтыг хавсаргасан гэх мэтээр баримтыг бүрдүүлсэн байна.
 - ✓ Аймгийн Засаг даргын 2016 оны 07-р сарын 05-ний өдрийн №А/387 тоотоор Үндэсний сурын Зуун мэргэн холбооны баг тамирчдад баяр наадмын бэлтгэлд 3.5 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэсэн ба бэлэн мөнгийг баг тамирчдад олгосон эсэх болон гардуулалтын баримт байхгүй, аймгийн Засаг дарга мөнгийг хүлээн авсан байна.
4. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаас батлагдаагүй санхүүжилт эх үүсвэрийг аймгийн Засаг даргын захирамжаар олгосон байна. Үүнд: аймгийн ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд
- аймгийн Засаг даргын 2016 оны 05-р сарын 23-ний өдрийн №А/279 тоот захирамжаар 2017 оны 05-р сарын 26-ний өдөр 20.0 сая төгрөгийг аймгийн Иргэний зөвлөлийн гишүүдийн урамшуулалын зардалд
 - аймгийн Засаг даргын 2016 оны 05-р сарын 23-ний өдрийн №А/416 тоот захирамжаар 2017 оны 07-р сарын 07-ний өдөр санхүүгийн дэмжлэг гэж 4.5 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын зарим дутагдаж буй зардлын эх үүсвэрийг санхүүжүүлэхэд зориулан санхүүжилтийн дэмжлэг гэж олгосон байна.
5. Тус харилцах дансаар ОНХСангийн эх үүсвэрээр хийгдэхээр батлагдсан аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн больницын урд авто зогсоолын зам засварын ажил 24.5 сая төгрөгийг 2017.01.27-ний өдөр, Шинэ худалдааны төвийн дэд бүтэц, тохижилтын

ажил /Битүү зах/ 34.2 сая төгрөгийг Амжилтын харгуй ХХК-д 2016.10.11-ний өдөр, Мөнгөнморьт сумын Зүүнбүрхийн голын гүүрийг засварлах 40.5 төгрөгийн 2017.04.27-ний өдөр нийт 99.2 сая төгрөгийн гүйлгээг, аймаг хөгжүүлэх сангийн 102.0 сая төгрөгийн, мал хамгаалах сангийн 20.0 сая төгрөгийн гүйлгээг хийснийг оны эцэст нэгтгэсэн тайланд хаана тусгагдаж байгаа нь журналын бичилтээр нотлогдохгүй байна.

6. Төсвийг аривлан хэмнэлтгүй зарцуулсан зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2016 оны 03-р сарын 10-ний өдрийн №А/105 тоот захирамжаар Науризын баяраар Монгол туургатан театрын уран бүтээлчид Өлгий хотод тоглох болсонтойгоор 4.2 сая төгрөгийг зарцуулсан боловч нэг ч төгрөгийн орлого оруулаагүй байна.
- Ажлаас халагдсаны болон тэтгэвэрт гарсан албан хаагчдад 85.7 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон.
- Баяр наадмын зардалд 70.7 сая төгрөг зарцуулсан.

7. Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлтэй холбоотой зарим зөрчлийг дурдвал:

-аймгийн ЗДТГ-ын 217.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засвар, тохижилтийн ажлыг 3 хувааж, харьцуулалтын арга хэрэглэн “Рэд лан” ХХК-тай 210.3 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, гүйцэтгүүлжээ. Уг засварын ажлын 60.9 сая төгрөгийн аймгийн ИТХ-ын хуралдааны танхим ажлын албаны өрөөний засварын ажлын худалдан авах ажиллагаа 2015 оны 12 сард хийгдэж, мөн ондоо ажил гүйцэтгэх гэрээ нь байгуулагдсан байна. Гэвч тухайн засварын ажлын зураг, төсөв 2016 онд хийгдсэн байна.

- Баян сумын дунд сургуулийн барилгын дээврийн засварын ажилд аймгийн ИТХ-ын тогтоолоор 60.0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэгчээр “Дуулгат мөрөн” ХХК шалгарч 59.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж ажил гүйцэтгүүлсэн байна. Мөн Баян сумын ЗДТГ-тай 39.8 сая төгрөгийн сургуулийн барилгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, ажлыг гүйцэтгэн санхүүжилт авсан байна. Уг ажлын зураг, төсвийг ажлын гүйцэтгэлтэй тулган үзэхэд нэг ажилд 2 гэрээ байгуулагдаж, 39.8 төгрөгийн санхүүжилтийг давхардуулан олгосон зөрчил илэрлээ.

Замын сан

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 сарын 04-ны өдрийн 11-р хуралдааны 09 тоот “Аймгийн 2016 оны төсөв батлах тухай” тогтоолын 3-р хавсралтаар замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг 304.0 сая төгрөгөөр 7 ажилд баталсан.

Замын сангийн эх үүсвэрээр хийгдсэн ажлын гүйцэтгэлийг шилгахад:

Орон нутгийн замын сангаас 316.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ажилд 286.0 сая төгрөг батлагдсан боловч 15 ажилд 413.1 сая төгрөгийн гэрээ байгуулагджээ. Эдгээр ажлуудад 398.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээс 2 ажлын 73.7 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хэмнэлтийн зардлаас санхүүжүүлсэн байна.

-Зуунмод сумын хатуу хучилттай авто замын ажил, авто замын засварт 175.0 сая төгрөг батлагдсан байна. Гэвч уг хөрөнгийн эх үүсвэр нь зураг, төсөвгүй батлагдаж, шинээр хийгдэх авто замын ажил болон замын засварын ажил гэсэн 2 өөр ажлыг нийлүүлж хөрөнгө батлуулснаас ИТХ-аас санхүүжих дүн нь батлагдсан 1 ажил нь нээлттэй тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах байсан боловч харьцуулалт болж 4 хуваагдан худалдан авалт хийгдэж, гэрээ байгуулагджээ.

Мал эмнэлгийн үйлчилгээний зардал

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 сарын 04-ны өдрийн 11-р хуралдааны 09 тоот “Аймгийн 2016 оны төсөв батлах тухай” тогтоолын 3.2-т мал эмнэлгийн үйлчилгээний зардлыг 421.3 сая төгрөгөөр баталсан байна.

Төрийн сангийн 140051000 тоот дансаар мал эмнэлгийн үйлчилгээ, шүлхий, цэцэг өвчний вакцинжуулалтанд нийт 479.2 сая төгрөг зарцуулагдсан.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардал

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлаас хэрэгжих Зуунмод сумын усан санг автоматжуулж, тоолууржуулах ажилд 300.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр батлагдсны дараа 297.4 сая төгрөгийн зураг, төсөв хийгджээ. Үүнд: Лүн суманд усны автоматжуулсан тоолуур тавих 9.9 сая төгрөг, Зуунмод суманд 10 усан сангийн барилга, тоног төхөөрөмж суурилуулах, усны нөөцийн сав нийлүүлэх гэсэн нийт 287.5 сая төгрөгийн ажил багтжээ.

Зуунмод суманд хийгдэх ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо 2016 оны 3 сарын 29-нд байгуулагдаж, 3 багц болгон хуваан худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Тус ажлын усан сангийн барилга болон тоног төхөөрөмж нийлүүлэх 2 багц ажлыг 246.8 сая төгрөгөөр гүйцэтгэх үнийн саналыг “Оргил сор” ХХК ирүүлж, 5 сарын 24-нд гэрээ байгуулах эрх олгогдсон байна. “Оргил сор” ХХК-аас ирүүлсэн төсөвт барилгын суурь болон фандусны ажлыг 28.0 сая төгрөгөөр гүйцэтгэх саналыг ирүүлжээ. Гэвч барилгын суурь болон фандусны ажлыг нийт 43.4 сая төгрөгөөр гүйцэтгэх ажлын гэрээг барилгын тусгай зөвшөөрөлгүй Төв Чандмань ДЭХГ-тай 4 сарын 22-ны өдөр байгуулсан байна.

11.5 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын талаар

Нэмэлт санхүүжилтийн дансны оны эхний үлдэгдэл 77.5 сая төгрөг, тайлант онд 1914.8 сая төгрөгийн орлого орж, 1981.8 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 8.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг авч үзвэл нийт зардлын 55.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 17.0 хувийг, цалин НДШ-д 6.0 хувийг зарцуулсан нь нийт зардлын 78.3 хувийг эзлэж байна.

зардлын нэр	мөнгөн дүн
Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл	120.4
Тогтмол зардал	58.4
Бараа материал хангамжийн	54.9
Эд хогшил, урсгал засварын зардал	60.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	326.7
Бараа үйлчилгээний бусад зардал	1059.4
Хөрөнгийн зардал	46.1
ОНТ-ийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас	134.5
Барилга байгууламж	19.8
Бие ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	26.3
Нормативт судалгаа	7.5
дүн	1914.8

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, эх үүсвэр бүрдүүлэлтэнд дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Аргалант сум нь 4.8 сая төгрөгийн татварын орлогыг, Алтанбулаг сум газрын суурь үнэ 6.7 сая төгрөгийг, Цээл сум нь газрын дуудлага худалдааны орлого 16.6 сая төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтын дансанд төвлөрүүлэн зарцуулсан
- Баян сум нь төрийн албан хаагчийн орон сууцны түрээсийн орлогын 1.1 сая төгрөгийг орон нутгийн татварын орлогын дансанд оруулалгүй сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтын дансанд оруулсан.
- Өндөрширээт сум нь Класнуэстайн майнинг ХХК-наас 0.3 сая төгрөгийн БОНСэргээлтийн барьцааг байршуулсныг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд оруулж зориулалт бусаар зарцуулсан

Дээрх алдаа зөрчил нь Төсвийн тухай хуулийн 47.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж, төсвийн жилийн явцад Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл, Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, төсвийн урамшуулалаас бүрдсэн эх үүсвэрийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно гэсэн заалтыг зөрчин татварын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар оруулан зарцуулсан байна.

11.6 Тусгай сангийн зарцуулалтын талаар

Төв аймгийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 27 сумын 148 сан, аймгийн 9 сан нийт 157 тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан, Мал хамгаалах сан, Байгаль хамгаалах сан, Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын харилцах дансад нь Төрийн санд, Эм эргэлтийн сангийн харилцах данс нь арилжааны банкинд байршиж үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргын тусгай сангуудын Аймгийн Хөгжлийн сан, Мал хамгаалах сан, Тариалан дэмжих сангуудын тайлант оны авлагын эхний үлдэгдэл 374.1 сая төгрөг, оны эцсийн үлдэгдэл 488.9 сая төгрөг болж 114.8 сая төгрөгөөр буюу 23.5 хувиар өсжээ. Энэхүү өсөлтөнд Тариалан дэмжих сангийн 41.3 сая төгрөгийн урьд оны үлдэгдлийг залруулсан, Аймгийн хөгжлийн сангаас 107.5 сая төгрөг, Мал хамгаалах сангаас 41.0 сая төгрөгийн зээл тус тус олгосонтой холбоотойгоор өссөн байна.

Нийт авлагын үлдэгдлийн 83.3 хувь буюу 406.7 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл эзэлж байгаа нь зээлийн эргэн төлөлтөнд тавих хяналт сул, урьд авсан зээлийн хугацаа хэтрэлттэй байхад нэмж зээл олгодог зөрчил дахин давтагдсаар байна.

Нийт авлагын 65.4 хувь буюу 319.5 сая төгрөг нь аймаг хөгжлийн сангийн зээл эзэлж байна. Энэ нь тариалалтыг дэмжих зориулалтаар үр тарианы аж ахуй эрхэлдэг 13 аж ахуйн нэгжид олгосон 204.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл эзлэж байна.

Аймгийн Тусгай сангуудын авлага

/ сая төгрөг/

№	Засаг даргын тусгай сангуудын нэр	2016.01.01-ний үлдэгдэл	Орлого	Зарлага	2016.12.31-ний үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл	
						үлдэгдэл	Хувь
1	Аймгийн хөгжлийн сан	279.2	107.5	67.1	319.5	279.2	87.4
2	Мал хамгаалах сан	48.8	41.0		89.8	48.8	54.3
3	Тариалан дэмжих сан	38.3	41.3		79.6	79.6	100
	нийт дүн	374.1	148.5	67.1	488.9	407.6	83.3

11.7 ТШЗ нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар тусгай сангуудын зарцуулалттай холбоотой гарсан зөрчлийн талаар дурдвал:

- ✓ Батсүмбэр сумын СХС-ийн жилийн эцэст байгаа зээл, хүүгийн авлага 250.5 сая төгрөгний 16.3 хувьтай тэнцэх 8 зээлдэгчийн 40.7 сая төгрөгний зээл хугацаандаа төлөгдөөгүй байна.
- ✓ Сүмбэр сумын СХС –ийн жилийн эцэст байгаа зээл, хүүгийн авлага 233.5 сая төгрөгний үлдэгдэлээс 83.2 хувьтай тэнцэх 91 зээлдэгчийн 194.3 сая төгрөгний зээл хугацаа хэтэрсэн байна. Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2015 онд тус сумын СХСанд ахуй үйчилгээний тоног төхөөрөмж 15.7 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилтийг олгож, 2015.02.10-нд 33 нэр төрлийн 15.7 сая төгрөгийн хөрөнгийг хүлээлгэн өгснийг иргэдэд гэрээгээр олгоогүй санхүүгийн тайланд хөрөнгөөр тусгаагүй байна.
- ✓ Цээл сумын СХС-ийн жилийн эцэст байгаа зээл, хүүгийн авлага 218.9 сая мянган төгрөгний 63.6 хувьтай тэнцэх 50 зээлдэгчийн 139.3 сая төгрөгний зээл хугацаандаа төлөгдөөгүй байна.
- ✓ Өндөрширээт сум нь тусгай сангуудын харилцах дансыг боловсруулж тайлагнаагүй.
- ✓ Эрдэнэ сумын СХСангийн авлагын эцсийн үлдэгдэл 246.9 сая төгрөгийн 217.4 сая төгрөг нь буюу 88.1 хувь нь хугацаа хэтэрсэн. 2016 оны 8-р сард олгосон 22.6 сая төгрөгний хүүг ашигласан сараар тооцолгүй, бүтэн жилээр жилийн 3 хувиар буюу 0.7 сая төгрөгийн хүү тооцож, 0.48 сая төгрөгөөр хүүг илүү тооцсон. Өмнөх онуудад авсан зээлийн дүнгээс хүү тооцон бүртгэж байгаагүй ба аудитын явцад нягтлан бодогчоор өмнөх онуудын зээлийн хүүг тооцуулахад 8.23 сая төгрөгийн зээлийн хүүг тооцон бүртгээгүй байна.
- ✓ Бүрэн сум 2015 онд СХСангийн хөрөнгөөр 20.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж авч иргэдэд, түрээслүүлэн төлбөрийг барагдуулахаар зээлээр олгосон ба оны эцэст 6.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг орон нутагт ашиглагдах нөхцөл боломжгүй гэдгээр бараа материалын дансанд үлдэгдлээр тайлагнагдсан.

- ✓ Сэргэлэн сумын СХСангаас нийт 90.0 сая төгрөгийн зээл графикын дагуу төлөгдөөгүй, гэрээний үүргээ биелүүлээгүйгээс дараагийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжгүй болгож СХСангийн орлого бүрдүүлэх нөхцөлийг хаагдуулсан байна.
- ✓ Эм эргэлтийн сангийн тайлангаар эмийн санчаас авах авлага Батсүмбэр сум 5.6 сая төгрөг, Бүрэн сум 7.9 сая төгрөг, Лүн сум 5.7 сая төгрөг байгаа нь авлагын зохистой үлдэгдлээс 5-8 дахин их байна.
- ✓ Өндөрширээт сум Эм эргэлтийн сангийн ажилчдаас авах авлага 16.4 сая төгрөгийн, Баянжаргалан сум Эм эргэлтийн сангийн тайланд авлагын дансанд тусгагдсан 2.4 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

11.8 Аймгийн орон нутгийн хөгжлийн сан

Аймгийн орон нутгийн хөгжлийн санд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 3323.4 сая төгрөг батлаж, төсвийн тодотголоор урьд оны үлдэгдэлээс 93.6 сая төгрөгийг нэмж батлан нийт 3417.0 сая төгрөг баталсанаас гүйцэтгэлээр 2620.3 сая төгрөгийг зарцуулж 797.0 сая төгрөгийн дутуу зарцуулалттай байна.

Зардлын төрлөөр ангилбал /сая:төг/

№	зардлын төрөл	зарцуулсан дүн	эзлэх хувийн жин
1	Гүүр засварлах	147.5	5.6
2	Их засварын ажил	1071.4	40.9
3	Зураг төсвийн зардал	272.0	10.4
4	Тоног төхөөрөмж бэлтгэх	142.2	5.4
5	Барилга байгууламж барих	352.1	13.4
6	Уурын зуух, тогооны шинэчлэл	259	
7	Худаг ус гаргах	376	
	нийт дүн	2620	

Нийт зардлын 40.9 хувь буюу 1071.4 сая төгрөгийн их засварын ажил эзэлж байна.

Хийгдсэн ажлуудаас батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн хийгдээгүй 3 төрлийн 474.1 сая

төгрөгийн ажил хийгдээгүй байна.

Төлөвлөгөөний дагуу бүрэн хийгдээгүй ажлуудыг дурьдвал

№	ажлын төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Сүмбэр сумын 100 хүүхдийн цэцэрлэг барилга	401.7	220.0	181.7	54.8
2	Иргэдийн нэгдсэн үйлчилгээний барилгын их засвар / Зуунмод /	196.3	8.9	187.4	4.5
3	ХАА-н машин тоног төхөөрөмж, эд ангиудыг сэргээн засварлах цех байгуулах /Цээл сум/	150.0	45.0	105.0	30.0
	ДҮН	748.0	273.9	474.1	

Батлагдсан төлөвлөгөөний дагуу 748.0 сая төгрөгийн хийгдэх ажлуудыг хугацаанд нь гүйцэтгээгүй, гүйцэтгэлд тавих хяналт сул зэргээс шалтгаалан 273.9 сая төгрөгийн дараах 3 ажлын гүйцэтгэлийг Сангийн сайдын 2012 оны 290-р тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалт санхүүжилт хяналт тайлагналтын шинэчлэгдсэн журмын дагуу тайлагнаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой гарсан зөрчилүүд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн дансны хуулга боловсруулаагүй, ня-бо журнал огт хөтлөөгүй, нэр данс зөрүүтэй 201.1 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн зэрэг нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг зөрчиж хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.
2. Орон нутгийн хөгжлийн сангаас 2015.12.23-ны өдөр Монте гео ХХК-ны Голомт банкны 1102030732 тоот дансанд 17.6 сая төгрөгийг санхүүжилтийн мэдэгдэл 173,174 тоот мэдэгдлээр шилжүүлсэн боловч Монте гео ХХК-ны Голомт банкны 1102030732 тоот дансанаас 2016.01.18-нд 8.6 сая төгрөг худгийн санхүүжилт гэж буцаж орж ирсэнийг 2016.01.18-нд Цахим ногоон ХХК-д урьд оны албан тоот, нэхэмжлэхийг канондон хавсаргаж 8.8 сая төгрөг шилжүүлж 0.18 сая төгрөг илүү шилжүүлсэн байна. Илүү шилжүүлсэн 0.18 сая төгрөгийг тооцоо нийлээгүй авлагаар тусгаагүй зөрчил илэрлээ.

3. ОНХСангаас аймгийн Засаг даргын 2016-07-01-ний А/361 дугаар захирамжаар Авъяас хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудын дизайн технологийн хичээлийн дадлагын байрны засвар үйлчилгээ, хэрэглэх тоног төхөөрөмжинд 46.0 сая төгрөг шилжүүлээд хэний эзэмшилд хаана бүртгэхийг шийдвэрлээгүйгээс хөрөнгийн бүртгэлд тусгаагүй зөрчил илэрлээ.
4. Аймгийн засаг даргын 2016.05.12-ны өдрийн А/262 дугаар захирамжаар ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Хүмүүн цогцолбор сургуулийн технологийн танхимын дадлагын ажилд шаардагдах тоног төхөөрөмж олон үйлдэлт принтер, бүрэгч машин дагалдах цаас хэрэглэлийн хамт 17.0 сая төгрөгөөр, мөн аймгийн Засаг даргын 2016.06.14-ний өдрийн А/336 дугаар захирамжаар ерөнхий боловсролын сургуулиудын дизайн технологийн сургалтанд хэрэглэгдэх 500 ш модон бэлдэц, зэс хөөмөлийг 2.0 сая төгрөгөөр нийт 19.0 сая төгрөгийн тоног тоног төхөөрөмжийг Төрийн бус байгууллага болох ЗЗБТөвд хөрөнгө бэлтгэж өгч байгаа нь авъяас хөтөлбөр нэртэйгээр хувийн байгууллагыг санхүүжүүлж зориулалт бус зардал гаргасан зөрчил илэрлээ.
5. Цээл сумын Хөдөө аж ахуйн машины засварын газрын ажилд 150.0 сая төгрөгөөр батлагдсаныг аймгийн ЗДТГазрын ХБХэлтсийн дарга, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэний өгсөн 44 тоот санхүүжилтийн мэдэгдэлээр 2016-06-08-нд ХАА-н машины тоног төхөөрөмж эд ангиудыг сэргээн засварлах цех байгуулах ажлын урьдчилгаа 45.0 сая төгрөгийг Дархан Үйлс ХХК-д шилжүүлсэн боловч авлагаар тусгаагүй зөрчил илэрлээ.
6. Боловсрол соёлын газрын дэргэд үлээвэр хөгжмийн хамтлаг байгуулахаар аймгийн Засаг даргын захирамжийн дагуу БСГазрын дарга 2016.05.18-нд Гурвансайхан мандуухай ХХК-иас 6 ширхэг үлээвэр хөгжим, том жижиг 2 бөмбөр, 1 цан гэсэн ком хөгжим худалдан авахаар 2016.05.19-нд гэрээ байгуулан тус ХХК-д 15.0 сая төгрөгийг шилжүүлэн үлээвэр хөгжмийг авсан гэх боловч хаана ямар байгууллагын эзэмшилд ашиглагдаж байгаа нь тодорхойгүй байхад авлагаар тусгаагүй байна.
7. ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөө Авъяас хөтөлбөрийн хүрээнд Бүрэн Зуунмод, Эрдэнэ, Заамар сумдын сургуулиудын шигшээ багийн тамирчдын жагсаал, бэлтгэлийн үед хэрэглэх биеийн тамирын нэг бүр нь 50.0 мянган төгрөгийн 80 ширхэг хувцасыг Боннтекстайл ХХК-иас худалдан авах гэрээ хийж 2016.06.14-нд 4.0 сая төгрөгийг шилжүүлж 0.7 сая төгрөгийн хувцасыг Бүрэн суманд өгч, бусад сумын сургуулиудад 3.3 сая төгрөгийн 66 хувцасыг нийлүүлээгүй зөрчил илэрлээ.

Арав хоёр. Эздийн өмчийн бүртгэл, тайлагнал

12.1 Эздийн өмчийн бүтцийн талаар

ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Хуримтлагдсан үр дүнгийн оны эхний үлдэгдэл 20114.8 сая төгрөгөөр тайлагнасан нь өмнөх оны үлдэгдлээс 0.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Бүрэн сум төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Э-Балансад шивэхдээ 0.8 сая төгрөгийг данс андуурч шивсэнтэй холбоотой байна. 2016 оны хуримтлагдсан үр дүн 32852.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	69,186.08	35,154.27	20,114.84	124,455.18
2	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	69,186.08	35,154.27	20,114.84	124,455.18
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	103.92	(1.35)	221.19	323.76
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	69,289.99	35,152.92	20,336.03	124,778.94
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.10	(524.24)	(1.15)	(525.29)
6	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(2,391.58)	(0.60)	1,453.64	(938.54)
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(0.98)	(0.19)	4.01	2.85
8	Тайлант үеийн үр дүн	0.15	-	11,057.54	11,057.69
9	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	66,897.70	34,627.89	32,852.18	134,377.77

2016 оны санхүүгийн тайланд залруулга хийсэнтэй холбоотой өмнөх үеийн үр дүн 1679.8 сая төгрөгөөр нэмэгдэж 34627.89 сая төгрөгөөр бүртгэсэн байна.

12.2 Засгийн газрын сангийн талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн Засгийн газрын сан оны эхний үлдэгдлээс 3.31 хувиар буурч 66897.7 сая төгрөг болсон байна. Засгийн газрын санг задалж үзвэл Аймгийн Засаг даргын 2016 оны 10 сарын 12-ны өдрийн А/582 дугаар захирамжаар “Солонго” цогцолборыг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын бүтцэд нэгтгэн өөрчилсөнтэй холбоотой 2277.67 сая төгрөгөөр, Зуунмод сумын Төв шинэчлэл төслийн нэгжийг Хот тохижуулахтай нэгтгэснээр 96.68 сая төгрөгөөр, “Чөлөөт Ахмадын холбоо”-г аймгийн “Аймгийн ахмадын хороо”-той нэгтгэснээс дээрх Засгийн газрын сан буурахад нөлөөлсөн байна.

12.3 Хөрөнгийн дахин үнэлгээний талаар

ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дахин үнэлгээний нөөц нь үндсэн хөрөнгө актлагдсантай уялдан 526.38 сая төгрөгөөр буурч, 2016 оны эцэст 34627.8 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Арван гурав.Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын бүртгэл, тайлагнал

13.1 ОНӨҮГ-ын бүтцийн талаар

Төв аймгийн ТЭЗ-ын санхүүгийн тайланд Төв аймгийн Чандмань ДЭХГазар, Зуунмод Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ, Жаргалант сум дах Томоко ОНӨААТҮГГазруудын санхүүгийн тайлангаа нэгтгүүлсэн байна.

Төв аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Жаргалант сум дах Томоко ОНӨААТҮГГазар нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа аудит хийж дүгнэлт гаргуулаагүй байна. Зуунмод Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ, Төв Чандмань ДЭХГ ОНӨҮГазрын санхүүгийн тайланд хамтран ажиллах гэрээний дагуу Их монгол хөлөг аудит ХХК аудит хийж дүгнэлт гаргасан.

Төв Чандмань -ДЭХ ОНӨҮГазар нь 2016 онд 5446.5 сая төгрөгийн орлогын, 5662.1 сая төгрөгийн зардлын батлагдсан төлөвлөгөөтэй ажилласнаас 6033.7 сая төгрөгийн орлоготой, 5950.1 сая төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 79.7 сая төгрөгийн борлуулалт марктенгийн, 59.0 сая төгрөгийн ерөнхий ба удирдлагын, 76.0 сая төгрөгийн бусад, нийт 6164.9 сая төгрөгийн зардалтай ажиллаж батлагдсан зардлыг 502.8 сая төгрөгөөр хэтрүүлэн 131.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Санхүүгийн аудитаар бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

1. 2016 оны эхний 6 сарын байдлаар нийт 5 байгууллагаас 10.0 сая төгрөгнөөс дээш 251.0 сая төгрөгийн худалдан авалтыг харьцуулалт хийхгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.
2. 2016 оны 12 сарын 31-ний байдлаар 3 байгууллагын он удаан жил болсон 6.7 сая төгрөгийн найдваргүй авлагатай байна.

Төв Чандмань -ДЭХ ОНӨҮГазрын 2016 оны санхүүгийн тайланд өмнөх аудитаар 5 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Төв Чандмань -ДЭХ ОНӨҮГазрын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 257.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 257.8 сая төгрөгийн 2 алдаа, цаашид анхаарч сайжруулах 1 асуудлаар нийт 3 зөвлөмж өгөгдсөн байна.

Зуунмод мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь 2016 онд 14.6 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны, 76.0 сая төгрөгийн бусад орлоготой, 111.1 сая төгрөгийн ерөнхий удирдлагын зардал, 5.2 сая төгрөгийн бусад зардал, 36.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна

Санхүүгийн аудитаар бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн журналд бүртгэхдээ цалингийн зардлыг махны мөнгө гэж бүртгэсэн, махны мөнгө олгосныг тооцооны дансаар дамжуулалгүй үйл ажиллагааны бусад зардал дансанд бичилт хийсэн, 4.7 сая төгрөгийн оны эхний үлдэгдэл махыг эрх бүхий албан тушаалтны шийдвэр болон үндсэн баримтгүйгээр тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан ашиг дансанд бичилт хийн данснаас хассан

2. 2016 оны эцэст 6.9 сая төгрөгийн авлага, 63.9 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, ажилтнуудад 1.0 сая төгрөгийн цалинг илүү, 0.1 сая төгрөгийн цалинг дутуу олгож цалинг нийгмийн даатгалын байгууллагад алдаатай тайлагнасан, санхүүгийн тайланд цалингийн өглөгийг 0.3 сая төгрөгөөр, НДШ-ийн өглөгийг 0.06 сая төгрөгөөр илүү, ХХОАТ-ын өглөгийг 0.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, Төв аймгийн Засаг даргын 2011 оны 09 сарын 22-ны өдрийн А/457 тоот захирамжийн дагуу мах бэлтгэх ажлын санхүүжилтэнд 50.0 сая төгрөг олгосныг 53.5 сая төгрөгийг Төв аймгийн Засаг даргын нөөц санд өгөх өглөгөөр одоог хүртэл бүртгэж ирсэн, 2012 оны 01 сарын 26-нд Аймгийн хөгжлийн сангаас авсан 65.7 сая төгрөгийн зээлийн гэрээний дагуу тооцсон 36 сарын хүү 1.3 сая төгрөг, 2013 оны 12 сарын 11-нд Аймаг хөгжүүлэх сангаас авсан 50.0 сая төгрөгийн зээлийн гэрээний дагуу тооцсон 36 сарын хүү 4.5 сая төгрөг, нийт 5.8 сая төгрөгийг өглөгөөр бүртгэж тайлагнаагүй байна.
3. Санхүүгийн байдлын тайлангийн хуримтлагдсан үр дүнгийн эхний үлдэгдлийн дүн өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдлийн дүнгээс 102.0 сая төгрөгөөр зөрүүтэй, эзэмшигчийн өмчийн бусад хэсэг дансанд эх үүсвэр нь тодорхойгүй 65.0 сая төгрөгийг бүртгэж ирсэн, хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдлийн дүн өмчийн өөрчлөлтийн тайлангийн эцсийн үлдэгдлийн дүнгээс 106.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.
4. Байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн баримт бичиггүй, Сангийн сайдын 2012 оны 77, 2014 оны 249 тоот тушаалууд, Шинэчлэн батлагдсан НББ-ийн болон Аудитын, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан тушаал зааврыг мөрдөөгүй байна.
5. Байгууллага нь орон тооны болон гэрээт нягтлан бодогчгүй байна.
6. Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн хэмжээ 800.5 сая төгрөгөөр бүртгэгдсэн ба санхүүгийн тайланд 1218.3 сая төгрөгөөр тайлагнагдсан нь 417.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна

Зуунмод мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 828.4 сая төгрөгийн материаллаг алдаа илэрсэнээс 389.8 сая төгрөгийн алдааг залруулж, 20.9 сая төгрөгийн 2 алдаанд зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 417.7 сая төгрөгийн залруулаагүй алдаа болон цаашид сайжруулах 5 асуудалд зөвлөмж өгөгдсөн.

Арван дөрөв. ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн түүний харьяа байгууллагуудын талаар

14.1 ТТЗ, ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд Ихмонгол хөлөг Аудит ХХК сумдын соёлын төв болон ОНӨҮГ, SM аудит ХХК сумдын Эрүүл мэндийн төв, сумдын цэцэрлэг, Уваа Уул Аудит ХХК зарим байгууллагуудад нийт 98 байгууллагад гэрээний дагуу аудитыг хийж, аймгийн аудитын газрын аудитор, шинжээч нар нь бусад 125 байгууллагуудад нийт 223 байгууллагад аудит хийсэн байна.

Аудитаар 215 байгууллагад санал дүгнэлт гаргаснаас 22 байгууллага буюу 10.2 хувьд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 193 байгууллага буюу 89.8 хувьд нь “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 13177.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 6642.9 сая төгрөгийн алдааг залруулж, 96.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 1341.9 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 22 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлж, 5079.2 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар 272 зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитаар “Хязгаарлалттай” дүгнэлтийн шалтгааныг хүснэгтээр харуулбал

№	“Хязгаарлалттай” дүгнэлт авсан байгууллага	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Заамар сумын Засаг дарга буюу ТТЗ	Орон нутгийн хөгжлийн сангийн 2.7 сая төгрөгийн өглөг, 161.1 сая төгрөгийн авлага, Сум хөгжүүлэх сангийн 323.7 сая төгрөгийн авлагуудыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 22.0 сая төгрөг буюу 21.9 хувиар тасалдуулсан зэрэг 509.5 сая төгрөгийн материаллаг хэмжээний алдаа зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн тул орлого, авлагын дансадын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
2	Борнуур сумын Засаг дарга буюу ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 13.8 хувиар буюу 10.2 сая төгрөгөөр тасалдуулсан, Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн ажлын гүйцэтгэлийг тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардалд бичсэн 53.9 сая төгрөгийн авлага зэрэг 64.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байх тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
3	Угтаал сумын Засаг дарга буюу ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 20.3 сая төгрөг буюу 47.1 хувиар тасалдуулсан алдаа зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн тул орлого дансны хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
4	Эрдэнэ сумын Засаг дарга буюу ТТЗ	Орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрсөн орлогыг 4.2 сая төгрөгөөр дутуу зөрүүтэй мэдээлсэн, 10 нэр төрлийн орлого 46.5 сая төгрөгөөр тасарсан нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
5	Бүрэн сумын Засаг дарга буюу ТТЗ	ЗДТГазрын эргэж төлөгдөх зээлийн зардалд 27.9 сая төгрөгийн төсвийг баталсан, гүйцэтгэлээр 61.0 сая төгрөг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөг 27.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. Энэ нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байх тул Сум хөгжүүлэх сангийн зээл олголтын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
6	Сүмбэр сумын Засаг дарга буюу ТТЗ	Улс, орон нутгийн орлогын төлөвлөгөө 3 шатандаа нийт 34.5 сая төгрөг буюу 21.3 хувиар тасалсан алдаа зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн тул орлогын дансдын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
7	Цээл сумын Засаг дарга буюу ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 5.8 сая төгрөг буюу 12.7 хувиар тасалдуулсан, газрын дуудлага худалдааны орлого 16.7 сая төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтын дансанд төвлөрүүлэн зарцуулсан алдаа зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн тул орлогын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
8	Баян сумын Засаг дарга буюу ТТЗ	Орон нутгийн хөгжлийн сангаас дунд сургуулийн барилгын дээврийн засварын ажилд хоёр тусдаа гэрээ байгуулагдаж, 39.8 сая төгрөгийн санхүүжилтийг давхардуулан олгосон, шүүхийн шийдвэрийн төлбөрт 12.0 сая төгрөг шилжүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байх тул Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын байдлын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
9	Мөнгөнморьт сумын Засаг дарга буюу ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн авлагыг зээлдэгч бүрээр хөтлөсөн жагсаалт, дэлгэрэнгүй бүртгэл байхгүй, зээлийн хүүг хэрхэн тооцсон нь ойлгомжгүй, 270.5 сая төгрөгийн авлага нь бодитой оршин байгаа эсэх нь аудитын явцад нотлогдохгүй байгаа алдаа зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байх тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
10	Алтанбулаг сумын Засаг дарга буюу ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн авлагыг зээлдэгч бүрээр хөтлөсөн жагсаалт, дэлгэрэнгүй бүртгэл байхгүй, зээлийн хүүг хэрхэн тооцсон нь ойлгомжгүй, 116.7 сая төгрөгийн авлага нь бодитой оршин байгаа эсэх нь аудитын явцад нотлогдохгүй байгаа алдаа зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байх тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
11	Аргалант сумын Засаг дарга буюу ТТЗ	Орон нутгийн төсвийн орлогыг 3 нэр төрлөөр 10.0 сая төгрөгөөр тасалсан, 4.8 сая төгрөгийн татварын орлогыг орлогын дансанд тушаалгүй ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд үлдэгдлээр тайлагнасан зэрэг нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
12	Баянхангай сумын Засаг дарга буюу ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 17.3 сая төгрөг буюу 46.8 хувиар тасалсан нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй тул орлогын дансдын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
13	Баянцагаан сумын Засаг дарга буюу ТТЗ	Улсын төсвийн орлого 357.0 сая төгрөгөөр, аймгийн төсвийн орлого 23.0 сая төгрөгөөр, орон нутагт төвлөрүүлэх орлого 4 нэр төрлийн орлого 6.2 сая төгрөгөөр нийт 386.2 сая төгрөгөөр татварын орлогын төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь урьдчилан

		тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй тул орлогын дансдын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
14	Өндөрширээт сумын ЗДТГ	Жолоочийн замын хуудасны тооцоог бодоогүй 12.4 сая төгрөгийн шатахуун олгосон, хэрэглэгчийн ажиллах маршрут хуудасгүйгээр шатахууны зөвшөөрөлийн хуудсыг олгодог зэрэг нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлийг хангаагүй тул шатахууны зардлын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
15	Заамар сумын ЗДТГ	Бараа үйлчилгээний урсгал зардлыг 9.1 сая төгрөгөөр бууруулсан, тооцооны дансаар дамжуулалгүйгээр 17.0 сая төгрөгийн гүйлгээнүүдийг шууд зардалд бичсэн зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлийг хангаагүй тул дээрх зардлын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
16	Аймгийн ЗДТГ	ХААН банкинд төсвөөс гадуур данс нээж 3.6 сая төгрөгийн түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлэлгүй зарцуулж санхүүгийн тайланд тайлагнаагүй, кассаар зарцуулсан 46.5 сая төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байгаа нь оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байх тул мөнгөн хөрөнгө дансны хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
17	Сэргэлэн сумын ИТХ	Сумын ИТХ нь 3.4 сая төгрөгийн шатахууны талон авсан боловч бараа материалын тайланд литрээр орлого авч зардалд тусгасан мөн дээрх шатахуунаар ажил гүйцэтгэсэн байдал нь жолоочийн замын хуудсаар хангалттай нотлогдохгүй байна. Энэ нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлийг хангаагүй тул дээрх зардлын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
18	Аймгийн ИТХ	Бараа материалын тайлан гаргаагүй шууд зардалд бичсэн, хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн зэрэг материаллаг хэмжээний 11.3 сая төгрөгийн алдаа зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байх тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
19	Өндөрширээт сумын ЕБС	Өмнөх болон завсарын аудитаас өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 43.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан акт, анхан шатны ямар ч нотлох баримтгүйгээр орлогыг бүртгэсэн зэрэг нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байх тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
20	Заамар сумын Эрүүл мэндийн төв	Мөнгөн хөрөнгийн данснаас шилжүүлсэн мөнгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичиж хаасан 6.2 сая төгрөг, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй зардалд бичсэн 2.4 сая төгрөг, худалдаж авсан материалыг шууд зардлаар бичсэн 1.4 сая төгрөгийн алдаа, зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлийг хангаагүй тул мөнгөн хөрөнгө дансны хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
21	Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэг	Балансаас балансад шилжиж ирсэн 519.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг засгийн газрын сан дансанд буруу бүртгэж орлого авсан ба үүний 484.5 сая төгрөгийн дүнтэй барилгыг анхан шатны нотлох баримтгүй бүртгэсэн байгаа нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлийг хангаагүй тул үндсэн хөрөнгө дансны хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
21	Монгол туургатан театр	Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь 33.1 сая төгрөг буюу 86.2 хувиар тасалсан нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.
22	Махны үйлдвэр	6.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэл, 8.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, хуримтлагдсан үр дүн дансанд үндсэн баримтгүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 4.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг хааж дансны бичилт хийсэн зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлийг хангаагүй тул авлага, өглөг дансдын хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.

14.2 Эрүүл Мэндийн байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 26 сумын Эрүүл мэндийн төв, Баруун-Зуунмод өрхийн эмнэлэг нийт 27 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 11 хуралдааны 2015 оны 12-р сарын 04-ний өдрийн 09 тоот “Аймгийн 2016 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор эрүүл

мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ 6872.7 сая төгрөг, өрхийн эмнэлэг 210.9 сая төгрөг нийт 7083.7 сая төгрөгөөр эх үүсвэрийг баталсан байна. Тайлант оны 2016.10.14-ны өдрийн ИТХ-ын 02 тоот тогтоолоор эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ 6864.1 сая төгрөг, өрхийн эмнэлэг 210.9 сая төгрөг нийт 7075.1 сая төгрөгөөр эх үүсвэрийг тодотгон батласан байна.

Эрүүл мэндийн сайдын багцын тусгай зориулалттай шилжүүлэгийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 229.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Эрүүл мэндийн салбарын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой болон хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой дараах алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд Мөнгөн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө, бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардал бүртгэх, дансны ангилалыг зөв хийгээгүйгээс зардал буруу тайлагнагдах, тогтоол шийдвэрийн дагуу ирсэн үнэ төлбөргүй хөрөнгө, бараа материалыг дутуу болон бүртгэж тайлагнахгүй байх, хөрөнгийн ангилалыг буруу бүртгэснээс бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэх, өглөг авлагын тооцоо нийлсэн актыг бүрэн хөтлөөгүйгээс өр авлагыг дутуу тайлагнах, жолоочийн авсан шатахууныг авлага үүсгэн тооцоог бодож зардалд бүртгэдэггүй, тооллого чанаргүй хийгддэгээс хөрөнгийг илүү, дутуу бүртгэсэн байх зэрэг алдаа зөрчил илэрсэн байна.

Аудитаар нийт 229.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 51.3 сая төгрөгийн залруулга хийгдэж, 16.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 7.9 сая төгрөгийн албан шаардлага, 153.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх, хариуцлагыг сайжруулах талаар 66 зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн байна.

14.3 Боловсролын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Төв аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 30 байгууллага, СӨБ-ийн 33 байгууллага, Хувийн хэвшлийн 7 цэцэрлэг, 1 сургууль нийт 71 байгууллага санхүүгийн тайланд аудит хийгдэхээс бүрэн хамрагдсан байна.

Ерөнхий боловсролын сургуулиудаас Өндөрширээт сумын сургуульд хязгаарлалттай санал дүгнэлт, 29 сургуульд зөрчилгүй санал дүгнэлт, 1 хувийн хэвшлийн сургууль түүвэрт хамрагдсан, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудаас Зуунмод сумын Унагалдай цэцэрлэг хязгаарлалттай санал дүгнэлт, 32 цэцэрлэгт “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, хувийн хэвшлийн 7 цэцэрлэг түүвэрт хамрагдсан байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3569.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2636.8 сая төгрөгийн алдааг залруулж, 22.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 31.0 сая төгрөгийн албан шаардлага бичигдэж, 879.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хариуцлагыг сайжруулах талаар 119 зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн байна.

14.4 Соёлын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Төв аймгийн соёлын салбарын 29 байгууллагаас аймгийн Монгол туургатан театр, номын сан, музей гэсэн 3 шууд захирагчийн санхүүгийн тайланд аймгийн Аудитын газрын аудитор, шинжээч нар, 26 сумын соёлын төвийн байгууллагын санхүүгийн тайланд гэрээний дагуу Их Монгол хөлөг аудит ХХК аудит хийж дүгнэлт гаргасан.

Аудитаар 29 байгууллагаас 28 шууд захирагчийн санхүүгийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт, Монгол туургатан театрын санхүүгийн тайланд “Орлогын” хувьд хязгаарлалттай санал дүгнэлт өгөгдсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 219.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 181.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, зөрчлийг таслан зогсоох 1.9 сая төгрөгийн албан шаардлага бичигдсэн ба 37.5 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгөгдсөн. Соёлын салбаруудын санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар илэрсэн зөрчлийг өмнөх онтой харьцуулахад 4.7 дахин буурсан сайн үзүүлэлттэй байна.

14.5 Аймгийн Засаг даргын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Ойн анги, Орон нутгийн өмчийн газар, Санхүү

хяналт, дотоод аудитын алба, Хот тохижуулах газар, аймгийн Ахмадын хороо, 26 сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, мөн 26 сумын Засаг даргын тамгын газрын нийт 59 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 11 дүгээр хуралдааны 2015 оны 12-р сарын 04-ний өдрийн 09 тоот “Аймгийн 2016 оны төсөв батлах тухай” тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн байгууллагын зардлыг 33805.6 сая төгрөгөөр баталсан байна.

2015 оны жилийн эцсийн шилжих үлдэгдлийг аймгийн ИТХ-ын 12 дугаар хуралдааны 2016 оны 03-р сарын 23-ны өдрийн 05 тоот “Аймгийн орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлийн жагсаалт батлах тухай” тогтоолоор 3346.3 сая төгрөгөөр батлажээ.

Тайлант оны 2016 оны 10-р сарын 14-ны өдрийн ИТХ-ын 02 тоот “Аймгийн 2016 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор орон нутгийн төсвийн байгууллагын төсвийг 33805.6 сая төгрөгөөр тодотгон батласан байна.

Аймгийн орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 18715.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Аймгийн орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой болон хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой дараах алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

- ✓ Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг мөрдөж ажиллаагүй байх
- ✓ Мөнгөн хөрөнгөөр худалдан авсан бараа материал, үндсэн хөрөнгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэх
- ✓ Үнэ төлбөргүй ирсэн хөрөнгө, бараа материалыг дутуу бүртгэх болон данс бүртгэлд тусгаагүй байх
- ✓ Хөрөнгийг буруу ангилан бүртгэснээс бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэх
- ✓ Шатахууныг зарцуулахдаа тооцоо боддоггүй, олгосон шатахууны дүнгээр зардалд бүртгэх
- ✓ Хөрөнгө, материалын тооллогыг чанаргүй хийж, тооцоо боддоггүйгээс хөрөнгийг илүү, дутуу бүртгэсэн байх
- ✓ Ажиллагсад олгосон цалингийн урьдчилгааг цалингийн өглөгөөр бүртгэх
- ✓ Авлага, өглөгийн тооцоо нийлсэн актыг бүрэн хөтлөөгүйгээс өр, авлагыг дутуу тайлагнах
- ✓ Дансны ангиллыг зөв хийгээгүйгээс орлого, зардал буруу тайлагнагдах
- ✓ Сангийн сайдын 2014 оны 5 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, ангиллыг ашиглах заавар", 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан журмыг зөрчин төсвийг зориулалт бусаар зарцуулах, зардлыг бүлэг хоорондын зохицуулалт хийх зөвшөөрөлг авалгүй зарцуулах
- ✓ Сумын төсвийн орлогод хамаарах орлогыг орон нутгийн татварын орлогын дансанд оруулалгүй сумын ЗДТГазрын “Нэмэлт санхүүжилт”-ын дансанд оруулж, шийдвэргүйгээр зарцуулсан зэрэг алдаа зөрчил илэрсэн байна.

Аудитаар нийт 19505.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 10038.3 сая төгрөгийн залруулга хийгдэж, 48.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 1720.3 сая төгрөгийн албан шаардлага, 8328.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх, хариуцлагыг сайжруулах талаар 275 зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн байна.

Арван тав.Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу ТЭЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэл, аймгийн татварын болон татварын бус орлого, аймгийн Засаг даргын данс болон тусгай зориулалттай сангуудын зарцуулалт, балансын дансад нийт 12 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдлүүд нь ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын санхүүгийн тайланг нэгтгэхдээ Санхүү үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны зэрэгцүүлсэн үзүүлэлтийг буруу дүнгээр нэгтгэх, мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгө, бараа материал, эздийн өмч дансдын эцсийн үлдэгдлийг буруу нэгтгэх зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Арван зургаа.Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан балансын дансдын үлдэгдлийг түүвэрлэн тулган шалгасан ба санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй аудитад хамрагдаагүй дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Арван долоо. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэгдсэн тайлангийн аудитын дүнгийн талаар 14.1-д, Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар 14.2-д, Боловсролын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар 14.3-д, Соёлын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар 14.4-д, Аймгийн Засаг даргын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар 14.5-д тус тус тусгасан.

ТЭЗахирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнгийн талаар болон Засаг дарга болон тусгай сангуудын дансдад хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

1. Төв аймгийн татварын болон татварын бус орлого нийт дүнгээрээ 1650.1 сая төгрөгөөр давж биелсэн ч нэр төрлөөр нь авч үзвэл бууны татвар 2.7 сая төгрөг, ТТАМАТөлбөр 8.3 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 16.1 сая төгрөг, үндсэн хөрөнгө борлуулсны орлого 32.4 сая төгрөг, өмч хувьчлалын орлого 41.7 сая төгрөг, ойгоос түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр 63.3 сая төгрөг, үйл ажиллагааны орлогын татвар 229.1 сая төгрөгөөр, нийт 393.6 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Улс, аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг жигд ханган биелүүлэх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2. Аймгийн татварын хэлтэс нь аймгийн нэр зааж ангилаагүй орлогыг 32.3 сая төгрөгөөр дутуу, АТБӨЯХТатварын орлогыг 19.5 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн, Зуунмод сум нь татварын мэдээ, санхүүгийн нэгтгэсэн тайландаа хог хаягдлын орлогыг 13.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, Сэргэлэн сум нь татварын мэдээндээ агнуурын нөөц ашигласны төлбөр 32.0 сая төгрөгийг нэр зааж ангилаагүй орлогоор бүртгэж тус тус мэдээ, тайланг зөрүүлсэн, цэргийн дүйцүүлэх албаны дансанд орсон 47.7 сая төгрөгийг орлогоор огт мэдээлээгүй нийт 77.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3-д Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ, 6.3.1-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, 6.3.2-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Орон нутгийн төсвийн орлогын мэдээг сар бүр татварын хэлтэстэй тулган баталгаажуулж Фрийбаланс програмд орлогын нэр төрлөөр үнэн зөв оруулж мэдээлж байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3. Бараа материалын дансны үлдэгдэлийг багцаар салгахад Баянчандмань сумын ЕБС, ХЗСС-ын Солонго цогцолбор гэсэн ТЗШ-ийн 2 байгууллагын 98.5 сая төгрөгийн үлдэгдлийг орон нутгийн төсөвт байгууллагын дүнд нэгтгэсэн, Монгол туургатан театрын бараа материалын эцсийн үлдэгдэл 16.9 сая төгрөгөөр дутуу нэгтгэгдсэн байна. Энэ УСНББОУС 6 стандартад “Байгууллага нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал зэрэг үзүүлэлтүүдийг мөр мөрөөр нь нэмэх байдлаар хяналт тавигч байгууллагын болон түүний хяналтанд байгаа байгууллагын санхүүгийн тайлангуудыг нэгтгэнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад дээрх алдааг залруулсан.

4. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний дүн нь сангийн яамтай тохирсон төсвийн хэлбэлзэлээр 74707.4 сая төгрөг байхад е тайланд 74504.9 сая төгрөгөөр тайлагнаж 202.5 сая төгрөгийн зөрүүтэй, гүйцэтгэл нь 70188.0 сая төгрөг байхад е тайланд 70180.5 сая төгрөгөөр татагдсанаас 7.5 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ УСНББОУС 6 стандартад “Байгууллага нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал зэрэг үзүүлэлтүүдийг мөр мөрөөр нь нэмэх байдлаар хяналт тавигч байгууллагын болон түүний хяналтанд байгаа байгууллагын санхүүгийн тайлангуудыг нэгтгэнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад дээрх алдааг залруулсан.

5. Төрийн сангийн 140051000 тоот харилцах данснаас ОНХсангийн эх үүсвэрээр хийгдэхээр батлагдсан 99.2 сая төгрөгийн гүйлгээг, аймаг хөгжүүлэх сангийн 102.0 сая төгрөгийн, мал хамгаалах сангийн 20.0 сая төгрөгийн гүйлгээг болон 2015 оны шийдвэр бүхий 126.6 сая төгрөгийг шилжүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7-р зүйлийн 7.1-д “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10-р зүйлийн 10.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно”, Төсвийн тухай хуулийн 6.4.2-д “төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх дансны харилцахын орлого, зарлагын гүйлгээг боловсруулан тайлагнаж, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

6. Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх зээлийн 80.8 сая төгрөгийн өр төлсөнийг зардлаар бүртгэж өглөгийг бууруулан тайлагнаагүй нь санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад дээрх алдааг залруулсан.

7. Угтаал сумын Засаг даргын тамгын газрын 5.6 сая төгрөгийн Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн биет бус хөрөнгийн эцсийн үлдэгдэл аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд дутуу татагдсан байна. Энэ УСНББОУС 6 стандартад “Байгууллага нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал зэрэг үзүүлэлтүүдийг мөр мөрөөр нь нэмэх байдлаар хяналт тавигч байгууллагын болон түүний хяналтанд байгаа байгууллагын санхүүгийн тайлангуудыг нэгтгэнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад дээрх алдааг залруулсан.

8. Бүтцийн өөрчлөлтөөр нийлсэн буюу тусгаарласан байгууллагуудын хөрөнгийг шалгаж үзэхэд Солонго цогцолборын дансанд байсан 778.2 сая төгрөгийн барилга байгууламжийг данснаас хассан боловч хүлээн авах байгууллага тодорхой биш холбогдох шийдвэр тогтоолд орхигдсон, ИТХ-ын 2015 оны 85 дугаар тогтоолоор татан буугдсан Тээвэр авто замын газрын балансад бүртгэлтэй 42.3 сая төгрөгийн хөрөнгийг Аймгийн ЗДТГ-т шилжүүлснийг бүртгэлд аваагүй байна. Энэ

УСНББОУС 6 стандартад “Байгууллага нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал зэрэг үзүүлэлтүүдийг мөр мөрөөр нь нэмэх байдлаар хяналт тавигч байгууллагын болон түүний хяналтанд байгаа байгууллагын санхүүгийн тайлангуудыг нэгтгэнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх байгууллагатай холбоотой хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх 820.5 сая төгрөгийн хөрөнгийг орлого авхуулахаар зөвлөмж хүргүүлэв.

9. 2016 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалт санхүүжилт хяналт тайлагналтын шинэчлэгдсэн журмын 6.1-д “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл худалдан авсан тоног төхөөрөмжийг хүлээн авсан эцсийн дүнгээр захиалагч бүртгэн санхүүгийн тайланд тусгана. Их засварын зардлыг захиалагч байгууллага нь хөрөнгийн дүн, засварын төрлөөр тодруулга тайланд тусгана” гэж заасныг дагуу захиалагч санхүүгийн тайланд тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн: Хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалт санхүүжилт хяналт тайлагналтын шинэчлэгдсэн журмын 6.1-д заасны дагуу бүртгэж тайлагнаж байх талаар зөвлөмж хүргүүлэв.

Материаллаг бус алдаа зөрчил илэрсэн байна Үүнд:

10. Аймгийн Засаг даргын тусгай сангуудын нийт авлагын үлдэгдлийн 83.3 хувь буюу 407.6 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл байгаа нь зээлийн эргэн төлөлтөнд тавих хяналт сул, урьд авсан зээлийн хугацаа хэтрэлттэй байгууллагад нэмж зээл олгосонтой холбоотой байна. Энэ нь Аймаг хөгжүүлэх сангийн журмын 5.2-т “Сангаас зээл, хөрөнгө оруулалтын санхүүжилт авсан аж ахуйн нэгж, байгууллага, сангийн хооронд гэрээгээр хүлээсэн эрх, үүрэгтэй холбогдсон маргааныг гэрээ байгуулагч хоёр тал харилцан тохиролцож чадахгүй бол хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ”, Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журмын 2.7.4-т “сангаас олгосон зээл, түүний эргэн төлөлтийн явцад үнэлэлт, дүгнэлт өгч, зээлийг хугацаанд нь төлүүлэх ажлыг эрчимжүүлэх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх 407.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар зөвлөмж өгөв.

11. Аймгийн мал хамгаалах санд өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхээр 2015 онд бэлтгэсэн 95.0 сая төгрөгийн өвс тэжээлээс 65.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 4.0 сая төгрөгийн үлдэгдлийг тайлагнаж, 25.2 сая төгрөгийн орлого дутуу төвлөрүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30.1-д “төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай сангийн зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан тайланд тусган санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 54.3-д “төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх 25.2 сая төгрөгийн өвсний тооцоог хийж төсөвт төвлөрүүлэх талаар зөвлөмж өгөв.

Арван найм. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад материаллаг 411.8 сая төгрөгийн алдааг залруулж, материаллаг бус 432.8 сая төгрөгийн алдааг залруулах боломжгүй болно.

Арван ес. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод хяналт хариуцлагатай холбоотой алдаа зөрчил ихээхэн гаргаж байгаа нь нягтлан бодогчидыг нягтлан бодох бүртгэл болон хууль эрх зүйн талаарх сургалтанд хамруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хорь. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацаанаас шалтгаалан аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Хорин нэг. ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Төв аймгийн ТЭЗахирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 2263.1 сая төгрөгийн материаллаг, материаллаг бус алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 411.8 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийн давтан гаргахгүй байх талаар 1851.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Хорин хоёр. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

Төв аймгийн ТЭЗахирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Төв аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар 3 зөвлөмжийг Төв аймгийн Засаг дарга, СТСХэлтсийн дарга нарт өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн хэрэгжилтийг 2016.07.01-ний өдөр №05/530 тоотоор ирүүлсэн. Аудитын явцад өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 2 зөвлөмж 66.6 дээш хувийн биелэлттэй, 1 зөвлөмж хэрэгжүүлээгүй байна. Хэрэгжээгүй зөвлөмжийг дурдвал:

- ✓ 11 сумын ЕБСургуулиуд болон соёлын төвүүдийн үндсэн хөрөнгийн дансны бусад үндсэн хөрөнгө ангилалд бүртгэлтэй байгаа 212.8 сая төгрөгийн номуудыг номын фонд ангилалд салгаж бүртгэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хорин гурав. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төв аймгийн ТЭЗахирагчийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшин 2465.4 сая төгрөгөөс материаллаг алдаа хэтрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өгөв.

Аудитлагдсан санхүүгийн тайлан хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР

Ц.САРАНЧИМЭГ

Ц.БАЗАРСАД

Т.МАЙЦЭЦЭГ

АУДИТОР

О.СОСОР

Ж.БЯМБАЦОГТ

ШИНЖЭЭЧ

Э.НАРАНТУЯА

Ц.ХИШИГЖАРГАЛ

А.БАТЛХАВГА

2017 оны 04 сарын 20

Хорин тав. Холбогдох байгууллагын санал



**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70273623, Факс: 70272237

2017. 04. 20 № 05/659
танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬАА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Төв аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн
2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд
хийсэн аудитын дүгнэлттэй танилцлаа.

Аудитын тайлангийн илэрсэн зөрчил дутагдлыг
арилгах, зөвлөмж дүгнэлтийн мөрөөр тодорхой арга
хэмжээ авч, эргэн тайлагнаж ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ю.БЯМБАЦОГТ

02 0561

My doc: -/2017 on/ A5 toot-2